



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 5.1.2, 6.7, 7.1 дэх хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18, 19 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан зааврыг мөрдөж хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Геронтологийн үндэсний төв (Р.Хишигжаргал)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 01 дүгээр тушаал, 2019 оны А/517 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141240112

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
дугаар 01 сарын 15 -ны өдрийн
А/22... дугаар тушаалын хавсралт



АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

ОРШИЛ

Дэлхий нийтээр ахмад настны тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Үүнтэй холбоотой Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангаас 2000 онд 60 ба түүнээс дээш настан 605 сая буюу 10 хувь байсан бол ахмад настан ойрын хэдэн арван жилд ялангуяа бага, дунд орлоготой орнуудад хурдацтай өсч 2050 он гэхэд дэлхийн хүн амын 22 хувь буюу 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш ахмад настан байх болно гэсэн тооцоолол байна.

Монгол Улс "Алсын хараа 2050"-д Монгол хүний дундаж наслалтыг 82 хүргэнэ гэж заасан.

Одоогийн ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь тэдний өвчин эмгэгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхээс гадна ахмад настны хам шинжийг эрт илрүүлэх, үнэлэх, тэдэнд үзүүлэх тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх асран хамгаалагчийг дэмжих зэрэг эрүүл мэнд, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлэх хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсын настны өвчлөлийн тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэнд судалгаагаар ахмад настны 12.6 хувь нь өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны алдагдалтай, 29.9 хувь нь өдөр тутмын багаж хэрэгсэлтэй харьцах үйл ажиллагааны алдагдалтай, 2.2 хувь нь танин мэдэхүйн чадвар буурсан, 16.4 хувь нь сэтгэл гутралтай байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын "Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн хэрэгцээг цогц байдлаар, урт хугацааны туршид тасралтгүй тусламж үйлчилгээгээр хангах" зөвлөмжид заасан "Ахмад настны цогц тусламж, үйлчилгээ(ICOPE) үзүүлэх заавар" гэдэг нь ахмад настны бие махбод, сэтгэц, нийгмийн байдлыг цогцоор үнэлэн, ахмад настны хам шинжийг эрт илрүүлж, түүнд суурилан эрүүл насжилтыг дэмжих, настанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг юм.

А.ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

А1. Хэрэглэгчид

Энэхүү зааврыг настны эрүүл мэнд, нийгмийн халамжийн чиглэлээр ажиллаж байгаа эмч, сувилагч, нийгмийн ажилтан үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

A2. Зааврын зорилго

Ахмад настны бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн байдлыг хам шинжийг илрүүлэх (ICOPE) үнэлгээгээр үнэлж, эрт илрүүлэн түүнд суурилан эрүүл насжилтыг дэмжих, настанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх, хянахад оршино.

A3. Зааварт ашигласан нэр томъёо, тодорхойлолт

- “Эрүүл насжилт” гэж үйл ажиллагааны чадварыг ахмад настанд сайн сайхан амьдрах боломж олгохуйц түвшинд хөгжүүлэх, хадгалах үйл явцыг;
- “Үйл ажиллагааны чадвар” гэдэг нь хувь хүний өдөр тутмын үйл ажиллагаа болон хүрээлэн буй орчин (гэр орон, олон нийт, нийгэм)-ны хоорондын харилцан үйлчлэлийн тусгалыг;
- “Ахмад настны цогц үнэлгээ” гэж ахмад настны эмч, мэргэжилтнүүд тухайн ахмад настны бие бялдар, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох оношилгооны олон талт үйл явцыг;
- “Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ (ICOPE) гэж ахмад настны бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн асуудлыг цогцоор үнэлэн, ахмад настны хам шинж, асран хамгаалал, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний хэрэгцээг тогтоож, тусламж, үйлчилгээг олон мэргэжлийн багаар цогцоор үзүүлж, эргэн хянах үйл ажиллагааг;
- “Гериатрийн хам шинж” (цаашид ахмад настны хам шинж гэх) гэж наснаас хамааралтай үүсэх олон хүчин зүйлээс шалтгаалсан эмнэлзүйн өөрчлөлт бөгөөд ахмад настны амьдралын чанарыг бууруулж, бусдаас хараат болох, урт хугацааны тусламж, үйлчилгээний хэрэгцээг үүсгэн эрүүл мэндийн эрсдэлийн улмаас эмнэлэгт хэвтэх улмаар нас барах эрсдэлд хүргэдэг үйл ажиллагааны чадвар алдагдлыг;
- “Насны доройтол” гэж ахмад настны хам шинжийн нэг бөгөөд наснаас хамааран олон эрхтэн тогтолцооны физиологийн нөөц, үйл ажиллагаа буурч, дотоод ба гадаа хүчин зүйлийн нөлөөнд өртөмхий болж улмаар эрүүл мэнд, бие даасан байдал алдагдан, нас барах эрсдэлийг нэмэгдүүлдэг эмгэг байдлыг;
- “Танин мэдэхүйн бууралт” гэдэг нь ой тогтоолт муудах, анхаарал сулрах, асуудлыг шийдвэрлэх чадвар буурах, настны өдөр тутмын үйл ажиллагааны чадвар нь даамжран буурах, тэнэгрэлийг үүсгэх шалтгаан болдог эмгэг байдлыг;
- “Ухамсарт ухаан балартал” гэдэг нь их тархины гадрын үйл ажиллагаа богино хугацаанд нэгэн зэрэг гэнэт хямарч танин мэдэхүйн цочмог өөрчлөлтөд орж баримжаа алдагдах, хий үзэгдэл, дэмийрэл зэрэг сэрэл мэдрэхүйн эмгэг шинжүүд илрэх, хэл яриа өөрчлөгдөх, ой тогтоолт буурах, ойгүйдлийн шинж илрэх, сэтгэлийн хөдөлгөөний талаас бухимдах эсвэл төрөл бүрээр өөрчлөгдөх, сэтгэл хөдөлгөөний догшролд эсвэл хөдөлгөөн хязгаарлагдах, орчноо бодитойгоор тусгаж чадахгүй байх, тусгаарлагдах, нойр- сэрүүн байдлын мөчлөг өөрчлөгдөх зэрэг шинжүүдээр илэрдэг эмгэг байдлыг;
- “Тэнэгрэл” гэж хувь хүний хэвийн байсан оюун ухааны чадвар болох ой тогтоолт, эргэцүүлэн тунгаан бодох чадвар, баримжаалах чадвар, танин мэдэхүйн чадварууд алдагдаж бусдын хараат болохыг;

- “Эмзэг бүлгийн ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ-үзүүлэх кэйс менежмент” гэж асран хамгаалагчгүй, ганц бие, бие даах чадваргүй, ахмад настны олон хам шинжтэй, гэр бүлийн гишүүдийн зүгээс дарамт шахалт, хүчирхийлэл үзүүлдэг, санхүүгийн эрсдэлтэй ахмад настанд нийгмийн хамгааллын тусламж үзүүлэхийг;
- “Сэтгэл гутрал” гэж идэвх санаачлага, сонирхол буурах, өөртөө итгэлгүй болох, сэтгэлээр унаж гуниглах гэсэн 3 шинжүүдээс аль нэг нь хоёр долоо хоногоос доошгүй хугацаанд илрэхийг;
- “Нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг.

A4. Тархварзүйн мэдээлэл

Дэлхий дахинд ахмад настны тоо эрчимтэй нэмэгдэж байгаа талаар Дэлхийн насжилтын хяналтын индекс (Global Age Watch Index) - 2015 судалгааны тайланд дурдсан байна. Өдгөө 60-аас дээш настай 901 сая ахмад настан амьдарч байгаа нь дэлхийн нийт хүн амын 12.3 хувийг эзэлж байгаа бол 2030 онд 1.4 тэрбум (16.5 хувь), 2050 онд 2.0 тэрбум (21.5 хувь) хүрэх төлөвтэй байна. Энэ нь манай гаригт амьдарч буй 10 хүн тутмын нэг нь 60, түүнээс дээш насны хүн ам байна гэсэн үг.

Хэрэв энэ хандлага хэвээр хадгалагдвал 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60, түүнээс дээш насны хүн ам болохоор байна. Монгол Улсын хувьд 60, түүнээс дээш насны хүн ам нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4 хувь байсан бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг тооцоолсон.

A5. Тавилан

Олон улсад хийгдсэн судалгаагаар насны доройтлын эмнэлзүйн үнэлгээ 7-9 дүгээр түвшин буюу хүнд зэрэгтэй үнэлэгдсэн ахмад настан 3.2 жил дотор нас барах эрсдэлтэйг тогтоожээ. 2021 онд Геронтологийн үндэсний төвөөс гаргасан “Доройтлын тархалтыг үнэлэх судалгаа”-нд ахмад настны 16.9 хувь нь насны доройтолтой, 54.6 хувь нь доройтолд орох эрсдэлтэй гэсэн судалгааны үр дүн гарчээ. Иймээс насны доройтолд хүргэдэг үндсэн шалтгаан болох ахмад настны хам шинжийг эрт илрүүлэн, цогц тусламж, үйлчилгээг үзүүлснээр эрүүл насжилтыг дэмжих чухал ач холбогдолтой.

Б. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Б.1. Анхан шатны болон лавлагаа шатлалын Эрүүл мэндийн байгууллагад эрт илрүүлгийг зохион байгуулах

Б.1.1. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, бусад холбогдох байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг:

- ✓ Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлт суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулна.

- ✓ ICOPE үнэлгээний ач холбогдлын талаар мэдээлэл өгнө.
- ✓ ICOPE үнэлгээг хийх аргачлалын сургалтад хамрагдсан байна.
- ✓ Хам шинжийг эрт илрүүлж, илэрсэн үйл ажиллагааны чадварыг дэмжих, хөгжүүлэх тусламж, үйлчилгээг эрт төлөвлөн хэрэгжүүлнэ.
- ✓ Хам шинжийг цаашид даамжрахаас урьдчилан сэргийлэхийн тулд бусдад таниулах, олон нийтэд суурилсан цогц арга хэмжээг авна.
- ✓ Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад илгээнэ.

Б.1.2. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хэрэгжүүлэх чиг үүрэг:

- ✓ Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлт суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулна.
- ✓ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, ахмадын төв, нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, асрамжийн төвөөс илгээсэн настан болон тусламж, үйлчилгээ авахаар ирсэн настанд хам шинж (ICOPE)-ийн үнэлгээнд хамрагдаж байсан түүхийг асууж тодруулан, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- ✓ Лавлагаа шатлалын эмнэлэг нь эрүүл насжилтыг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, биеийн тамир, спортоор хичээллүүлэх, гериатрийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, хянах чиглэлээр Б.1.2-т заасан байгууллагын эмч, мэргэжилтэн, ажилтанг сургах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Б.1.3. Геронтологийн үндэсний төвийн хэрэгжүүлэх чиг үүрэг:

- ✓ Ахмад настны тусламж, үйлчилгээний зааврын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- ✓ ICOPE үнэлгээ хийх аргачлалын талаар сургалт зохион байгуулна.
- ✓ Холбогдох байгууллагаас илгээсэн настанд хам шинжийн дахилт, даамжралаас сэргийлэх хоёрдогч урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Б.2. Зорилтот бүлэг

Б.2.1. ICOPE үнэлгээнд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй хамрагдана.

Б.3. Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө

Тусгайлан бэлтгэл шаардлагагүй. Настны үнэлгээний үргэлжлэх хугацаа 1.5-2 цаг байдаг. Ахмад настны хам шинжийн үнэлгээг хийхийн өмнө биеийн эрүүл мэнд, сэтгэц, танин мэдэхүйн байдлыг харгалзан үнэлгээний үргэлжлэх хугацааг тогтооно. Настанг ядраах, залхаахаас сэргийлж, үнэлгээний ач холбогдлыг тайлбарлаж, ойлгуулна. Эмнэлзүйн байдал тогтвортой буюу архаг өвчний эзэнгшлийн үед настны цогц үнэлгээг хийнэ. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, асрамжийн төв, настан судлалын кабинет, тасаг, нэгж нь эрүүл настанг жилд нэг удаа, хам шинж илэрсэн болон архаг хууч өвчинтэй ахмад настанг хагас жилд нэг удаа тус зааврын В бүлэгт заасан үнэлгээ, сорил, шалгуурыг ашиглан хам шинжийг давхардуулалгүй эрт илрүүлнэ.

ICOPЕ үнэлгээнд хамрагдсан ахмад настанд үнэлэгдсэн үнэлгээний хуудсыг өгч, үнэлгээнд хамрагдах хугацааг тэмдэглэж хэлнэ.

В. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ (АЛГОРИТМ)

В.1. АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

Настны хам шинжийг эрт илрүүлэх биеийн эрүүл мэнд, танин мэдэхүй, сэтгэл санааны байдал (сэтгэл түгшил, сэтгэл гутрал), мөн настны нийгмийн байдал (ганцаардал гэх мэт)-ыг холбогдох үнэлгээ, сорил, шалгуураар үнэлж, оношлон, тэдгээрийн хэрэгцээ болон хувь хүний онцлог, үнэт зүйл, итгэл үнэмшил, хүсэл сонирхол, хүйсийн ялгаатай байдалд үндэслэн тусламж, үйлчилгээг төлөвлөн үзүүлнэ.

В.1.1. Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPЕ үнэлгээ

Ахмад настанд зонхилон тохиолдох хам шинжийг эрт илрүүлснээр, хариу арга хэмжээг эрт төлөвлөн хэрэгжүүлж, эрсдэл, хүндрэлээс сэргийлэх ач холбогдолтой.

Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPЕ (Хүснэгт 1) цогц үнэлгээний бүрэлдэхүүнд танин мэдэхүйн чадвар бууралт, хөдөлгөөний чадвар бууралт, хоол тэжээлийн доройтол, харааны бэрхшээл, сонсголын бэрхшээл, сэтгэл гутрал ордог.

Хүснэгт 1

Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPЕ үнэлгээ, сорил

Ахмад настны хам шинж	Илрүүлэх асуумж, сорилууд	Хариулт
ТАНИН МЭДЭХҮНИ ЧАДВАР БУУРАЛТ	<ul style="list-style-type: none"> Гурван үг тогтоолгох: адуу, дөрвөлжин, жүрж Цаг хугацаа, орон зайн баримжаа: өнөөдөр хэдэн сарын хэдний өдөр вэ Гурван үг санах чадвар 	<input type="radio"/> хариулж чадахгүй эсвэл буруу хариулах <input type="radio"/> гурван үгээ эргүүлэн санаж чадахгүй байх
ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДВАР БУУРАЛТ	Сандлаас босох сорил: гараа цээжиндээ зөрүүлээд 5 удаа сандлаас босч суух хугацааг үнэлнэ. 14 секунд ба түүнээс дээш хугацааг зарцуулж байна уу	<input type="radio"/> Үгүй
ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДОРОЙТОЛ	<ul style="list-style-type: none"> Сүүлийн 3 сарын хугацаанд санамсаргүйгээр 3 кг-аас дээш жин хаясан уу Хоолны дуршил буурсан уу 	<input type="radio"/> Тийм <input type="radio"/> Тийм
ХАРААНЫ БЭРХШЭЭЛ	<ul style="list-style-type: none"> Танд ойрын зүйл харахад бэрхшээл тулгардаг уу Нүдний хараанд нөлөөлөх нүдний өвчин, чихрийн шижин, артерийн даралт ихсэлт гэх мэт архаг өвчин байдаг уу 	<input type="radio"/> Тийм
СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛ	Өөрийн өгүүлэмжээр сонсгол бууралттай настанд шивнээ ярианы сорил аудиометрийн шинжилгээ	<input type="radio"/> Гүйцэтгэж чадахгүй байх
СЭТГЭЛ ГУТРАЛ	Сүүлийн 2 долоо хоногийн турш танд санаа зовоосон дараах асуудал байсан уу Сэтгэлээр унах, гутрах, итгэл найдвараа алдах Аливаа зүйлийг хийх идвэх сонирхол буурч байсан уу	<input type="radio"/> тийм <input type="radio"/> тийм

ICOPE үнэлгээний бүх асуултанд “Үгүй” гэж хариулсан тохиолдолд бие махбод, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг эрүүл гэж үзэж “Эрүүл настан” гэж тооцож, зөвлөгөө өгнө. ICOPE үнэлгээний аль нэг асуултад “Тийм” гэж хариулсан тохиолдолд лавшруулан оношлох алгоритмын дагуу оношилно.

В.1.2. Эрүүл настанд өгөх нийтлэг зөвлөгөө

- ✓ Эрүүл настанд тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмч, сувилагч, нийгмийн ажилтан, нийгмийн халамжийн ажилтан ахмад настны хам шинжийг илрүүлэх асуумжид жилд нэг удаа хамруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийн зөвлөгөө, мэдээлэл өгч, ахмад настны хам шинжээс сэргийлэх;
- ✓ Танин мэдэхүйн чадвар бууралтаас сэргийлж идэвхтэй насжилтыг дэмжих төвд хамрагдан шинэ найз нөхөдтэй болж, ном унших, танин мэдэхүйн тоглоом тоглох, шинэ зүйл суралцах, сайн дурын ажил эрхлэх, залуучуудыг сургах г.м нийгмийн идэвхтэй харилцаанд тогтмол орж ганцаардлаас сэргийлэхэд анхаарах;
- ✓ Хөдөлгөөн алдагдахаас урьдчилан сэргийлэн булчингийн хүч, сунгалт болон тэнцвэрийн дасгалыг зааж сургах, явганаас унахаас сэргийлж, ахмад настны амьдарч буй орчинг үнэлэн, ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөгөө өгөх,
- ✓ Хоол тэжээлийн доройтолд орохоос сэргийлэн хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон, зөв хадгалж, зөв боловсруулан “Гэр” зөвлөмжийн дагуу зохистой харьцаагаар, тохиромжтой цагт хооллох талаар зөвлөгөө өгч зааж сургах,
- ✓ Харааны бэрхшээлээс сэргийлэхийн тулд жилд нэг удаа харах чадвараа тодорхойлуулах, нүдний угийг дурандуулахыг зөвлөхөөс гадна амьдарч буй орчны байгалийн болон зохиомол гэрэлтүүлгийг сайжруулах, гар утас тогтмол хэрэглэх, телевизорыг удаан хугацаагаар үзэх, гэрэлтүүлэг муутай нөхцөлд ном унших гэх мэт хорт зуршлаас зайлсхийхийг зөвлөх,
- ✓ Сонсгол бууралтаас сэргийлэхийн тулд чимээ шуугиан багатай орчинд байх, чихэвчээр тогтмол юм сонсохгүй байх, сонсголоо тогтмол шалгуулж байх талаар зөвлөх,
- ✓ Сэтгэл гутралаас сэргийлэхийн тулд шинэ найз нөхөдтэй болох, гэр бүл найз нөхөдтэй хамт цагийг өнгөрөөх, үр хүүхэдтэйгээ тогтмол уулзах, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын ажил хийх, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, ижил сонирхолтой бүлэгт нэгдэх шинэ зүйл сурч мэдэх,
- ✓ Нийгмийн идэвхтэй харилцааг дэмжихийн тулд туршлагаа хуваалцах, хөдөлмөр эрхлэх, бусдад туслах, сайн дурын ажилд оролцох, идэвхтэй насжилтыг дэмжих төвд хамрагдах, холбон зуучлах гэх мэт тусламж, зөвлөгөөг үзүүлнэ.

В.1.3. Хам шинжтэй настанд үзүүлэх нийтлэг эмчилгээ, зөвлөгөө

Ахмад настны хам шинжийн ICOPE үнэлгээний дүнд үндэслэн үнэлгээгээр илэрсэн үйл ажиллагааны алдагдал, өөрчлөлт, хам шинж бүрт тохирсон тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

В.1.4. Архаг өвчин сэдэрсэн, тусламж, үйлчилгээ авч чадахгүй гэртээ байгаа настанд үзүүлэх нийтлэг эмчилгээ, зөвлөгөө

Хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настанг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс гэрээр сувилахуйн болон сэргээн засахын тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Настанд үзүүлэх хам шинжийн эмчилгээ, зөвлөгөөг төлөвлөхдөө настны архаг өвчин, хам шинж, эрсдэлт хүчин зүйлсийг заавал анхаарна. Настны архаг өвчин сэдэрсэн тохиолдолд эмчилнэ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй, байнгын асаргаа сувилгаа, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ шаардлагатай настанг "Кэйс менежмент"-ийн үйлчилгээнд хамруулж, олон мэргэжлийн багаар үзүүлэх тусламж, үйлчилгээг төлөвлөн, үзүүлж хянана. Үзүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- ✓ Олон мэргэжлийн баг, хамтарсан баг настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох,
- ✓ Тулгамдсан асуудлыг эрэмбэлэх,
- ✓ Настан бүрт тохирсон тусламж, үйлчилгээний төлөвлөгөө/хөтөлбөрийг боловсруулахдаа үр хүүхэд, асран хамгаалагчийг оролцуулахаас гадна, өөрийг нь оролцуулах,
- ✓ Бие даан аюулгүй орчинд амьдрах, хувь хүний хөгжлийг хадгалах, эрүүл мэндээ хамгаалах зэрэг хамгийн үнэ цэнэтэй зүйлээ хийх боломжийг олгоход анхаарах,
- ✓ Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдал, эмчилгээ, асаргаа сувилгааны ахиц дэвшлийг харьцуулан үр дүнд тогтмол хяналт хийж, эмчилж, сувилан эрүүлжүүлэх.

Архаг хууч өвчин сэдэрсэн настанд дараах нийтлэг эмчилгээ, үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- ✓ Үндсэн өвчинг эмчлэхдээ хэрэглэж байгаа эмийн төрөл, эмийн эмчилгээний үр дүн, хэрэглэж буй эмийн харилцан нөлөөлөл, гаж нөлөөнд үнэлгээ өгч, эмийн зөв зохистой хэрэглээний талаар зөвлөнө.
- ✓ Настанд нэг өдөр хэрэглэж байгаа эмийн тоо 5 ба түүнээс дээш байгаа тохиолдолд тухайн ахмад настанг *олон эмийн хэрэглээтэй* ахмад настан гэж үзэж, шаардлагагүй, үр дүнгүй, хавсарсан нөлөөтэй эмийг хасах замаар олон эмийн хэрэглээг бууруулна.
- ✓ Настанд хэрэглэх эмийг хэдэн цагт, хэдэн ширхэгээр, яаж уух талаар тодорхой бичиж тэмдэглэж өгөх, эмээ яаж, хэрхэн ууж байгаад нь хяналт тавьж, зааварчлах, эмээ нөөцлөх, хадгалах талаар тайлбарлан ойлгуулах замаар ахмад настан болон асран хамгаалагчдад эмийн тогтвортой хэрэглээ, эмийг аюулгүй уух талаар мэдээлэл өгнө.
- ✓ Шаардлагатай тохиолдолд хяналтын эмчид үзүүлж зөвлөгөө авна.
- ✓ Өвчин сэдэрч, хурдан даамжран хүндэрч байгаа, ахмад настны олон хам шинж илэрсэн, энэ нь ахмад настны амьдралын чанарт нөлөөлж байвал эмчид үзүүлнэ. Эмчийн зөвлөсөн эмчилгээний дагуу эмчилгээг хийнэ.

В.1.5. Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж үзүүлэх шалгуур

Анхны болон яаралтай тусламжийг Эрүүл мэндийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үзүүлнэ.

В.2. ТАНИН МЭДЭХҮЙН ЧАДВАР БУУРАЛТЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ


В.2.1. ICOPRE үнэлгээний танин мэдэхүйн чадвар бууралтыг лавшруулан оношлох алгоритм

Танин мэдэхүйн чадвар бууралттай ахмад настанд тусламж, үйлчилгээг хавсралт дахь алгоритмын дагуу үзүүлнэ.

ISCOPE үнэлгээний танин мэдэхүйн чадвар бууралтыг илрүүлэх “цаг хугацаа орон зайн баримжаа үнэлэх” асуултанд хариулж чадахгүй эсвэл буруу хариулах, “гурван үг тогтоолгох сорилт”-ыг гүйцэтгэж чадахгүй буюу 3 ба түүнээс бага оноо авсан тохиолдолд “Одоогийн сэтгэцийн байдлыг үнэлэх Фолштэйны буюу Mini–Mental State Examination /MMSE/ асуумж” (Хүснэгт 2)-аар лавшруулна оношилно.

Хүснэгт 2.

Одоогийн сэтгэцийн байдлыг үнэлэх Фолштэйны сорил

Гүйцэтгэх даалгавар	Оноо
<u>Баримжаалал</u> Настнаас он, сар, улирал, өдөр, гариг асууна.	5 оноо
Настнаас яг одоо хаана байгааг асуух /гэртээ, эмнэлэгт, орон нутагт, өөр орон нутагт, өөр улсад/	5 оноо
<u>Богино хугацааны ой тогтоолт</u> Настанд өөр хоорондоо ижил утгын холбоогүй 3 үгийг хэлж өгөөд цээжилсэн эсэхийг эргэж асууна. Жнь: /муур, сандал, огторгуй гм/ Настан эдгээр үгийг эхний болон дараагийн удаад хэлж чадахгүй бол дахин асууна. /6 удаа асууна./	3 оноо
<u>Анхаарал болон тоо бодлогын чадвар</u> Настнаар 100-аас 7-г хасуулж бодуулаад үлдэгдэл бүрээс дахин 77-г хасуулах байдлаар асууна. Энэ үйлдлийг 5 удаа хийлгэнэ.	5 оноо
<u>Урт хугацааны ой тогтоолт</u> Настнаар өмнө нь цээжлүүлсэн 3 үгийг давтан хэлүүлнэ. /давтан хэлж өгөхгүйгээр/	3 оноо
<u>Хэл яриа ба дадсан хөдөлгөөн</u> Настнаас харандаа, бугуйн цаг 2-ыг харуулаад нэрийг нь асуух	2 оноо
Настнаар үгүй, “тийм”, үгүй “гэвч”, үгүй “эсвэл” гэсэн үгүүдийг давтан хэлүүлэх	1 оноо
Настнаар дараах 3 үйлдлийг дэс дарааллаар хийлгэх. Жнь. Ширээн дээрээс хуудас цаас аваад, нугалаад, хаяарай гм.	3 оноо
“Нүдээ ань” гм хялбар хийж болох ямар нэгэн заавар бичсэн цаасыг настанд өгч гүйцэтгүүлнэ.	1 оноо
Настнаар ямар нэгэн богино өгүүлбэр бичүүлэх	1 оноо
Өөр хоорондоо нийлсэн 5 өнцөгт дүрсийг дуурайлган зуруулах	1 оноо
	
Нийт авах оноо	30

Фолштэйны буюу Mini–Mental State Examination (MMSE) сорилоор өгөгдсөн даалгаврыг тайлбарлан ойлгуулж, сонсож байгааг шалган даалгаврыг гүйцэтгүүлж, гүйцэтгэж байгаа байдлыг ажиглан тэмдэглэнэ. Тус сорилоор 24-30 оноо авсан бол “Танин мэдэхүйн чадвар хэвийн”, 23-18 оноо авсан бол “Танин мэдэхүйн чадварын бага зэргийн бууралттай”, 17 ба түүнээс бага оноо авсан тохиолдолд “Танин мэдэхүйн чадварын хүнд зэргийн бууралттай” гэж тус тус оношилно.

Хэрвээ ахмад настан харилцан ярилцах чадвартай, бүрэн бус дундаас дээш боловсрол эзэмшсэн тохиолдолд Монтериалын сорил(Хүснэгт 3)-ын дагуу лавшруулан эмч, сувилагч оношилно.

Хүснэгт 3.

Танин мэдэхүйн хөнгөн зэргийг үнэлэх асуумж (Montreal Cognitive Assessment - MoCA)

МОНТРЕАЛИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ҮНЭЛГЭЭ (МОСА*) Хувилбар 8.3 Монгол (Монгол улс)		Хүйс:..... Боловсрол:..... Ажил:..... Хаяг:.....	Төрсөн он сар өдөр:..... Мэргэжил:..... Гэр бүлийн байдал:..... Огноо:.....
ХАРААНЫ БАРИМЖАА / ГҮЙЦЭТГЭЛ Эхлэл Төгсгөл []		Орыг хуулж зурах []	Цаг зурах (Зүү нь 05 цаг 10 минут байх) (3 оноо) [] [] [] [] [] [] Гадна хүрээ Тоо Зүү
НЭРЛЭХ []		[]	[]
ОЙ ТОГТООЛТ Үгсийг та уншиж өгнө. Үйлчлүүлэгч гэдгээр үгсийг дэргэдээ давтаж хэлж бөгөөд, Эхний удаа амжилттай хэлсэн ч гэсэн 2 удаа заавал давтаж хийнэ. 5 минутын дараа санаж байгаа эсэхийг нь шалгана.		ХӨЛ ХӨВӨН СУРГУУЛЬ УЛААН ЛООЛЬ ЦАГААН 1 дэх удаа 2 дахь удаа	ОНОО өгөхгүй
АНХААРЛ Цуваа тоонуудыг (1 тоог секундийн хурдтайгаар) уншиж өгнө.		Үйлчлүүлэгч хэлсэн дарааллын дагуу давтаж хэлнэ [] 2 4 8 1 5 Үйлчлүүлэгч дарааллыг урвуугаар давтаж хэлнэ [] 4 2 7	
Цуваа үсгүүдийг уншиж өгнө. Энэ үед үйлчлүүлэгч А үсэг хэлэх болонд ширээг товших бөгөөд. Хэрвээ 2 ба түүнээс олон алдвал оноо өгөхгүй.		[] ФБАСМНААЖЛБАФАКДЭАААЖАМОФААБ	
60-аас 7-өөг хаасан үйлдэл:		[] 53 [] 46 [] 39 [] 32 [] 25	4-5 нь зөв бол 3 оноо, 2-3 нь зөв бол 2 оноо, 1-ийг зөв бол 1 оноо, нэгийг ч зөв бэлдсгүй бол 0 оноо.
ХЭЛ ЯРИА Давтаж хэлэх:		Хүү шонь дундаас хойш нохойгоо зугаалуулдаг байв. [] Үзэсгэлэнгийн үеэр зураач зурсан зургаа дуусгажээ. []	
Аман ярианы чадвар: 1 минутанд "Б" үсгээр эхэлсэн үг аль болох олонг нэрлээрэй.		[] _____ (≥ 11 ба түүнээс олон үг хэлсэн)	
ХИЙСЭР СЭТГЭХҮЙ Ижил төстэй шивнэгийг хэлэх. Жиш: банана-журж = жомс		[] Алх - Биэх	[] Шүдэнз - Чийрэн
СЭРГЭЭН САНАХ (MIS)		ХӨЛ ХӨВӨН СУРГУУЛЬ УЛААН ЛООЛЬ ЦАГААН	Оноог зөвхөн өөрөө зөв санасан үгсийг тоогоор өгнө
Сангах ойн индексийн оноо (MIS)		X3 БИЕ ДААЖ ООРОО САНАХ [] [] [] [] [] X2 Ерөнхий утгаар санах [] [] [] [] [] X1 Олон утгаар санах [] [] [] [] []	MIS = ____ / 15
БАРИМЖААЛАЛ		[] Он [] Сар [] Өдөр [] Гариг	[] Дүүрэг/Сум [] Хот/Аймаг
© Z Nasreddine MD www.mocatest.org		MIS: /15 (Хэвнийн ≥ 26/30)	
Шинэжилтэй хийсэн хүн: _____ Баталгаажуулахын тулд сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авах		≤ 12 жил сурсан бол 1 оноо нэмнэ үү.	
		НИЙТ ОНОО ____/30	

Монтериал сорилд өгөдсөн даалгаврыг гүйцэтгүүлж, даалгаврыг гүйцэтгэж байгаа байдлыг ажиглан тэмдэглэж, оноо өгнө. 26 ба түүнээс дээш оноо авсан "Танин

мэдэхүйн чадварын бага зэргийн бууралттай", 24 ба түүнээс доош оноо авсан "Танин мэдэхүйн чадварын хүнд зэргийн бууралттай" гэж үнэлнэ.

В.2.2. Танин мэдэхүйн чадвар бууралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

Танин мэдэхүйн чадвар бууралтад нөлөөлж буй дараах эрсдэлт хүчин зүйлсийг сувилагч, нийгмийн ажилтан тодруулах шаардлагатай. Үүнд:

- Хоол шим тэжээлийн доройтол, хүнд хэлбэрийн шингэн алдалт, хоол шим тэжээлийн хангалтгүй хэрэглээ, хооллож чадахгүй байх,
- Ухамсарт ухаан балартах,
- Олон эмийн хэрэглээ,
- Сэтгэл гутралын хам шинж,
- Тархины судасны хатуурал, зүрх судасны өвчний хүндрэл г.м.

Эдгээр эрсдэлт хүчин зүйлс нь настанг дэмийрэлтэй, тэнэгрэлтэй мэт харагдуулдаг тул ялган оношлох шаардлагатай.

- Сэтгэл гутрах өвчин эмгэгтэй эсвэл хам шинжийн эмнэлзүй нь танин мэдэхүйн чадвар бууралттай андуурагдах магадлалтайг,
- Ухамсарт ухаан балартал нь бие даасан өвчин биш бөгөөд халдварт өвчин, хордлого, гэмтэл, олон эмийн хэрэглээ, бодисын солилцооны эмгэгийн хам шинжийг,
- Олон эмийн хэрэглээтэй ахмад настан ялангуяа тайвшруулах, нойрсуулах эмийг байнга хэрэглэдэг, томоохон мэс засал, ерөнхий мэдээ алдуулалтын дараа танин мэдэхүйн бууралт үүссэн эсэх,
- тархины харвалт, тархины ишемийн шинж илэрч байсан түүхтэй өгүүлэмжтэй эсэхийг асууж тодруулна.

В.2.3. Танин мэдэхүйн чадвар буурсан үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

Олон улсын өвчний ангилал (ICD10)-аар R32 буюу танин мэдэхүйн чадвар бууралт оношлогдсон ахмад настанд тархины цусан хангамжийг дэмжих, мэдрэлийн эсийн бодисын солилцоог сайжруулах эмийн эмчилгээ хийнэ. Тэнэгрэл оношлогдсон тохиолдолд ДЭМБ-аас гаргасан mhGAP (сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчигээний) удирдамжийн дагуу оношилгоо, эмчилгээ хийнэ.

Одоогийн сэтгэцийн байдлыг үнэлэх Фолштэйны буюу Mini-Mental State Examination (MMSE) сорилоор "Танин мэдэхүйн чадварын бага зэргийн бууралттай" настанд танин мэдэхүйн бууралтыг гүнзгийрүүлэхгүй байх, түүнийг хадгалахад дараах тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Настны гэр бүл, асран хамгаалагчид настны өрөөнд цаг тооны бичиг, цаг, телевиз, радио байрлуулан цаг хугацааны баримжаа, цаг үеийн мэдээллээр хангах,
- Нийгэмд болж буй үйл явдал болон гэр бүлийн зургийн цомог үзүүлэн ярилцах, гэр бүлийн ярианд настанг татан оролцуулж, тэдний үзэл бодлыг сонсох
- Хамт кино үзэх, ном унших, шүлэг, дуу цээжлүүлэх, үгийн сүлжээ бөглөх, таавар таах зэрэг оюуны чадвар хөгжүүлэх дасгал ажиллуулах,

- Гар урлал, шүр хэлхэх, юм эвлүүлэх, шинэ зүйлд сургах,
- Ахмад настан болон үр хүүхэд, асран хамгаалагчид нь дээрх эмчилгээг зааж өгөх, танин мэдэхүйн чадварын бууралт нэмэгдвэл эмчид хандахыг зөвлөх,
- Оюуны чадварыг сайжруулах сэдэвчилсэн хичээлийн агуулгатай боловсролын сэргээн засах хөтөлбөр, клуб, дамжаа, идэвхтэй насжилтыг дэмжих төвийн ганцаарчилсан болон бүлгийн хөтөлбөрт хамруулах талаар нийгмийн ажилтан, халамжийн ажилтанд холбон зуучлах.

Танин мэдэхүйн чадвар бууралтад хүргэж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах нь эмчилгээнд чухал ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Хоол тэжээлийн доройтол нь настанг дэмийрэлтэй, тэнэгрэлтэй мэт харагдуулдаг тул түүнд хүргэж буй үндсэн шалтгааныг тодорхойлж, холбогдох байгууллагын ажилтантай хамтран ажиллана.
- ✓ Олон эмийн хэрэглээтэй настан ялангуяа тайвшруулах, нойрсуулах эмийг байнга хэрэглэдэг бол эмийг хасах, хасч чадахгүй бол эмчээс зөвлөгөө авна.
- ✓ Тархины харвалт, тархины ишемийн шинж илэрч байсан түүхтэй өгүүлэмжтэй настанд цусны даралтаа тогтмол хянаж, эмчийн хяналтанд байж, эмээ тогтмол уухыг зөвлөнө.
- ✓ Зүрх судасны өвчний эрсдэлээс сэргийлэхийн тулд тамхинаас гарах, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл зөв хооллох талаар зөвлөнө. Тархины цусан хангамж сайжруулах, мэдрэлийн эсийн бодисын солилцоо дэмжих эмийн эмчилгээг хийлгэхийг зөвлөнө.
- ✓ Ахмад настан сэтгэл гутрах эмгэг эмгэгтэй эсвэл эмнэлзүйн хам шинжтэй бол эмчид хандана.

В.2.4. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

- Фолштейны сорилоор 17 ба түүнээс бага оноо, Монтериалын сорилоор 24 ба түүнээс бага оноо тус тус авсан "танин мэдэхүйн чадвар хүнд зэрэг буурсан" настанг,
- Дэмийрлийн шинж тэмдэг тогтмол илэрч, эмчилгээний үр дүн муу, солиорлын шинж тэмдэг тод илэрч байгаа үед,
- Амиа хорлох эрсдэлтэй, нийгэмд аюултай үйлдэл хийх магадлалтай үед,
- Тархи, зүрх судасны өвчинг оношлох, явц, даамжралыг тодорхойлох, эмчлэх зорилгоор илгээнэ.

В.3. ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДВАР БУУРАЛТЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

В.3.1. ICOPPE үнэлгээний хөдөлгөөний чадвар бууралтыг лавшруулан оношлох алгоритм

Дасгал хөдөлгөөн бол эрүүл насжилтыг тодорхойлох, бие даасан байдлыг хадгалах, бусдын тусламж дэмжлэгээс хараат бус байхад ач холбогдолтой. Хөдөлгөөний чадвар бууралттай ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг хавсралт дахь алгоритмын дагуу үзүүлнэ.

Хөдөлгөөний чадвар бууралтыг үнэлэх "Сандлаас босч суух сорил"

"Сандлаас босч суух сорил"-ыг Зураг 1-т үзүүлсний дагуу гүйцэтгүүлнэ. Сорилыг дараах зааврын дагуу сувилагч, нийгмийн ажилтан хийлгэнэ.

Гарыг энгэрт тэврүүлэн сандлаас босох сорилыг хийж хөлийн хүчийг үнэлнэ. Ахмад настны 5 удаа гарын тусламжгүйгээр сандлаас босох хугацааг тэмдэглэнэ. Ахмад настан тав дахь удаагаа боссоны дараа (зогсоо байрлалд) секунд хэмжигчийг зогсооно.




Зураг 1. Босч суух сорил

Хэрэв настан гараараа тулан босч байгаа тохиолдол, нэг минутын турш сорилыг хийж чадаагүй бол ахмад настан тэнцвэр алдагдалтай, сорилын үед унах аюултай бол сорилыг зогсооно.

Биеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн сорил

Босч суух сорилоор "Хөдөлгөөний чадвар бууралттай" гэж үнэлэгдсэн ахмад настанг биеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн сорил (Зураг 2)-ын дагуу лавшруулан оношилно. Тус сорил нь гурван энгийн сорил буюу тэнцвэр үнэлэх сорил, 4 метрт алхах хурд үнэлэх сорил, өмнө гүйцэтгэсэн босч суух сорилын онооны нийлбэрээр үнэлэгдэнэ.

Зураг 2 . Биеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн сорил



Дээрх 3 сорилын тэнцвэр үнэлэх сорилыг хийж гүйцэтгэхдээ гурван өөр байрлалд тэнцвэрээ хадгалах ёстойг тайлбарлаж анхааруулна. Сорилыг хийлгэж байгаа ажилтан өөрийн биеэр хийж харуулна.

Нэгдүгээр сорил болох тэнцвэр хадгалах сорилыг дараах дэс дараалал, тайлбарын дагуу гүйцэтгэнэ.

А. Хөлийг зэрэгцүүлсэн байрлал

Эхний байрлалд хөлөө нийлүүлэн 10 секундын турш зогсох шаардлагатай. Та тэнцвэрээ хадгалахын тулд гараараа тэнцвэрээ хадгалах, өвдгөө нугалж, биеэ хөдөлгөж болно, гэхдээ хөлөө шалнаас хөндийрүүлэхгүй, юу ч барихгүй байхыг хичээнэ. Зогсоох командыг сонсох хүртэл 10 секундын турш энэ байрлалд байна.



Сувилагч ахмад настан өөрөө (хэн нэгний тусламжгүйгээр) зогсож байгааг хармагцаа секунд хэмжигчийг ажиллуулна. 10 секундын дараа, эсвэл ахмад настан хөлний байрлалыг өөрчлөх эсвэл тэнцвэр хадгалахын тулд ямар нэгэн зүйлд хүрмэгц цагийг зогсооно.

Б. Хагас зэрэгцүүлсэн байрлал

Дараагийн байрлалд нэг хөлөө бага зэрэг урагш тавьж, нэг хөлний хуруу нь нөгөө хөлийн дунд түвшинд байхаар байрлуулан, хоёр хөлийн дотоод гадаргуу нийлж байхаар 10 секундын турш зогсох хэрэгтэй. Та хүссэнээрээ хөлөө урагшлуулж болно. Та тэнцвэрээ хадгалахын тулд гараараа тэнцвэрээ хадгалах, өвдгөө нугалж, биеэ хөдөлгөж болно, гэхдээ хөлөө шалнаас хөндийрүүлэхгүй, юу ч барихгүй байхыг хичээнэ. "Зогс" командыг сонсох хүртэл энэ байрлалд байна.



Сувилагч, нийгмийн ажилтан ахмад настан өөрөө (хэн нэгний тусламжгүйгээр) зогсож байгааг хармагцаа секунд хэмжигчийг ажиллуулна. 10 секундын дараа, эсвэл өвчтөн хөлний байрлалыг өөрчлөх эсвэл тэнцвэр хадгалахын тулд ямар нэгэн зүйлд хүрмэгц цагийг зогсооно.

В. Хоёр хөлөө урд урд нь угсруулан байрлуулах

Сүүлийн байрлал: нэг хөлийн өсгий нь нөгөө хөлийнхөө хурууны урд байхаар зогсож түүнд хүрнэ. 10 секундын турш энэ байрлалд зогсоно. Хөлөө өөрт хамгийн тохиромжтой байдлаар бага зэрэг урагшлуулж болно. Та тэнцвэрээ хадгалахын тулд гараараа тэнцвэрээ хадгалах, өвдгөө нугалж эсвэл биеэ хөдөлгөж болно, гэхдээ хөлөө шалнаас хөндийрүүлэхгүй байхыг хичээ. "Зогс" командыг сонсох хүртэл энэ байрлалд байхыг хичээ.

Сувилагч ахмад настан өөрөө (хэн нэгний тусламжгүйгээр) зогсож байгааг хармагцаа секунд хэмжигчийг ажиллуулна. 10 секундын дараа, эсвэл өвчтөн хөлийн байрлалыг өөрчлөх эсвэл тэнцвэр хадгалахын тулд ямар нэгэн зүйлд хүрмэгц цагийг зогсооно.

Хоёрдугаар сорил болох 4 метрт алхах хурдыг үнэлэхдээ "Эхлэх" тэмдгээс 4 метрийн зайг хэмжиж тэмдэглэнэ. Ахмад настан хэвийн хэмнэлтэйгээр тэмдэглэсэн шугам хүртэл алхсан хугацааг үнэлнэ. Сорилыг тухайн хүний ихэвчлэн өмссөн гуталтай нь үнэлдэг.

Гуравдугаар сорил болох сандлаас босч суух сорил Зураг 2-т заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

Дээрх гурван сорилын нийлбэр оноог Зураг 3-т тайлбарласны дагуу тооцоолно. Үүнд:

10-12 оноо авсан бол “Хөдөлгөөн хэвийн”, 0-9 оноо авсан бол “Хөдөлгөөний чадвар бууралттай” гэж үзнэ.

В.3.2. Хөдөлгөөний чадвар бууралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

Хөдөлгөөний чадвар бууралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг сувилагч, нийгмийн ажилтан тодруулна. Үүнд:

- Олон эмийн хэрэглээ: хөдөлгөөнийг удаашруулж, тэнцвэрт нөлөөлдөг эм болох уналт, таталтын эсрэг эм, бензодиапезин, бензодиазепин бус нойрсуулах эм, гурван цагирагт антидепрессант, серотонины эргэн шимэгдэлтийг сонгомлоор дарангуйлагч (SSRI) антидепрессант, сэтгэцийн эм болон опийн бүлгийн эм гэх мэт эмийг хэрэглэж байгаа эсэхийг,
- Ясны сийрэгжилт, саркопени, яс үений үрэвсэл, яс үений эмгэг,
- Насны доройтол,
- Хөдөлгөөнтэй холбоотой үүссэн өвдөлт байгаа эсэхийг асууж тодруулна.

В.3.3 Хөдөлгөөний чадвар буурсан үед үзүүлэх үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

Хөдөлгөөний чадвар бууралтад хүргэж буй ясны сийрэгжилт, яс үений үрэвсэл, яс үений эмгэг, насны доройтол, саркопени өвчнийг холбогдох оношилгоо, эмчилгээний зааврын дагуу оношилж эмчилнэ.

Биеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн сорилоор “Хөдөлгөөний чадвар бууралттай” гэж оношлогдсон настанд хөдөлгөөний чадварыг сайжруулахын тулд дараах эмчилгээ, зөвлөгөөг өгнө. Үүнд:

- ✓ Сэргээн засах эмчилгээ/ тулгуур эрхтний сэргээн засах тусламж, үйлчилгээ,
- ✓ Сэтгэл зүйн эмчилгээ хийх,
- ✓ Бариа засал, зүү эмчилгээ хийх,
- ✓ Явж, хөдлөхөд дэмжлэг болох, ортопед болон туслах хэрэгсэл (таяг, тэргэнцэр, гэх мэт), ортопед (гарын чиг гэх мэт), харааны бэрхшээл (нүдний шил, цагаан таяг), сонсголын хэрэгсэл(сонсголын аппарат)-ийг үр дүнтэй зөв сонгож, зөв тогтмол хэрэглэх, засч сэлбэх, орчинд нь тохируулан хэрэглэх аргыг зааж өгөх,
- ✓ Олон төрөлтөт багц дасгал зааж өгч хийлгэх,
- ✓ Хөдөлгөөнийг удаашруулж, тэнцвэрт нөлөөлдөг эм болох уналт, таталтын эсрэг эм, бензодиапезин, бензодиазепин бус нойрсуулах эм, гурван цагирагт антидепрессант, серотонины эргэн шимэгдэлтийг сонгомлоор дарангуйлагч (SSRI) антидепрессант, сэтгэцийн эм болон опийн бүлгийн эм гэх мэт зарим хэрэглэж байгаа эмийг эмчийн заалтгүй хэрэглэж байвал хасах, хэрэв эмийг хасах шийдвэр гаргаж чадахгүй байвал мэргэшлийн эмчээс зөвлөгөө авч шийдвэрлэх.

Хөдөлгөөний чадвар бууралтад хүрээлэн буй орчны нөхцөл байдал нөлөөлдөг тул гэрийн гадаад, дотоод орчныг аюулгүй, ээлтэй бүрдүүлэх талаар зөвлөгөө өгнө.

Настанд ээлтэй, аюулгүй гадаад орчныг бүрдүүлэх

Сууц өмчлөгчдийн холбоо, баг, хороо, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, сайн дурын болон үйлчилгээний газар, дэлгүүр, худалдааны газрын ажилтан нарын

оролцоо, дэмжлэгтэйгээр гадаад орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх талаар зөвлөнө.

Үүнд:

- ✓ тэргэнцэртэй хүмүүст зориулж, стандартын дагуу орчныг тохижуулах,
- ✓ явган хүний замын гадаргуу эвдрэл гэмтэлгүй, хальтарч гулгахгүй материалаар хийгдсэн байх,
- ✓ орчны гэрэлтүүлэг бүрэн, шатны өндөр тохиромжтой, хөдөлгөөнгүй бэхлэгдсэн бариултай, цахилгаан шат ажиллагаатай байх,
- ✓ амарч суух сандал хүрэлцээтэй байх,
- ✓ Орчин тойронд эмх цэгц, настны хөдөлж явах хэсэг дэх саад бэршээл: явган замын эвдрэл гэмтэл, нүх, овоолсон шороо гэх мэтийг зайлуулах, засах гэх мэт

Настанд ээлтэй, аюулгүй дотоод орчныг бүрдүүлэх

- Гэрийн хана, ариун цэврийн өрөө болон гэр дотор явахад тулах түших бат бэх бэхэлсэн бариул бий болгох,
- Хальтрахгүй материалаар хийгдсэн шалтай байх, хивс, дрож, хулдаасыг хөдөлгөөнгүй бэхлэх,
- Шалны овойлт, хулдаасны уранхайг засах, гэрийн тавилгыг хөлд тээглэхээргүй байрлуулах,
- Цахилгааны утас, уртасгагчийг хөлд тээглэхээргүйгээр далдлах,
- Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг тод нүд гялбахгүйгээр, сүүдэрлэхгүйгээр байх,
- Шөнийн цагаар босч бие засдаг настанд зөөврийн суултуур, хөтөвч ашиглуулах.

Настны бие даах чадварыг сайжруулах, алдагдсан чадварыг сэргээн засах

- Хөдөлгөөний алдагдлыг засах туслах хэрэгслийг зөв сонгож, тогтмол зөв хэрэглэх аргыг зааж өгөхөөс гадна тулгуур эрхтний сэргээн засах тусламж үйлчилгээнд явуулна.
- Олон төрөлтөт багц дасгалыг тухайн настны хөдөлгөөний чадвар болон эрүүл мэндийн байдалд үндэслэн төлөвлөнө:
 - ✓ Булчингийн хүчний дасгал: туухай, эсэргүүцэлт резинэн тууз эсвэл биеийн жингээр хийх дасгал, жишээ нь: скуат буюу суултын дасгалууд;
 - ✓ Аэробик/зүрх судасны дасгал, тухайлбал хурдан алхах, дугуй унах зэрэг бага зэрэг амьсгалын тоог нэмэгдүүлж, зүрхний цохилтыг хурдасгадаг дасгалууд;
 - ✓ Тэнцвэрийг хөгжүүлэх дасгал; нүд нь хараатай, аниатай үед янз бүрийн байрлалд шилжих боломжтой; Жишээ нь нэг хөл дээрээ зогсож, өсгий, өлмийгөөр шулуун шугамаар алхах дасгал;
 - ✓ Булчин болон зөөлөн эдийн сунах чадвар, үе мөчний хөдөлгөөний далайц, уян хатан байдлыг сайжруулдаг дасгал; Жишээ нь сунгалт болон бусад йог болон пилатес дасгал буюу бүтэн биеийн чангалах дасгал;

Дасгалын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд уургийн хэрэглээ, бусад шим тэжээл нөхөх г.м эрүүл хооллолтын зөвлөмжтэй хавсран хэрэгжүүлнэ.

Дасгал заах, түүнийг хийлгэхийн өмнө тухайн настны эрүүл мэндийн байдлын талаар асууж тодруулна.

- Тайван үед цээжээр өвдөж байсан уу?
- Та сүүлийн зургаан сарын дотор зүрхний шигдээсээр өвдсөн үү?
- Та ухаан алдаж унасан уу?
- Та сүүлийн 12 сарын хугацаанд явганаас унасан уу?
- Та сүүлийн нэг сард ясаа хугалсан уу?
- Хувцаслах гэх мэт гэртээ өдөр тутмын энгийн ажил хийхэд амьсгаадаж байна уу?
- Та дасгал хөдөлгөөн хийхэд хөдөлгөөнийг хязгаарладаг үе мөч, булчингийн өвчин байна уу?
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн таныг дасгал хөдөлгөөнийг хязгаарлаарай гэж хэлсэн үү?

Хэрэв ахмад настан дээрх асуултын аль нэгэнд "тийм" гэж хариулсан бол хөдөлгөөн засалч, сэргээн засахын эмч, сувилагч, мэргэжилтэн ахмад настанд тохирсон дасгалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Дасгалын ачааллаас болж булчинд өвдөлт үүсвэл дасгал хөдөлгөөнийг зогсоохгүйгээр өвдөлт намжтал дасгалын эрчмийг бууруулна. Өвдөлт намдсан үеэс дасгалын эрчмийг аажмаар нэмж, тогтмол хийснээр биеийн уян хатан байдал сайжирч, өвдөлтийг даван туулахад тусалдаг. Хөдөлгөөний чадвар бууралттай, тэнцвэр алдагдалтай хүмүүс орон дээр эсвэл сандал дээр сууж дасгал хийх нь зүйтэй. Тэнэгрэл гэх мэт танин мэдэхүйн доройтолтой ахмад настанд энгийн, цөөн тоотой дасгалыг зааж өгнө.

В.3.4. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

- Хөдөлгөөний чадварын бууралт нь танин мэдэхүй чадварын бууралт, мэдрэхүйн эрхтний чадвар бууралт, сэтгэл гутралтай хавсарч байвал насны доройтлын үнэлгээ хийлгэхээр ахмад настны төрөлжсөн мэргэшлийн эмчид,
- Эпилепси, паркинсоны хам шинж, паркинсоны өвчний үед мэдрэлийн эмчид,
- Хөдөлгөөний чадвар дангаар болон танин мэдэхүйн чадвар бууралт эсвэл хавсарсан архаг суурь өвчний үед хөдөлгөөн хязгаарлагдвал тохирох дасгалын хөтөлбөрийг боловсруулахын тулд сэргээн засахын эмчид тус тус илгээнэ.

В.4. ХООЛ ШИМ ТЭЖЭЭЛИЙН ДОРОЙТЛЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

В.4.1. IСOPE үнэлгээний хоол шим тэжээлийн доройтлыг лавшруулан оношлох алгоритм

Хоол шим тэжээлийн доройтолд настны эрүүл мэндийн шалтгааны улмаас хоол шим тэжээлийг хангалтгүй хэрэглэх, хооллож чадахгүй байх, амтлах, үнэрлэх мэдрэмж буурах, зажлах, залгихад хүндрэлтэй байх, нийгмийн талаас хоолоо өөрөө хийж идэж чадахгүй байх, хүнсээ цуглуулж чадахгүй байх, ганцаараа амьдрах, орлого багатай байх зэрэг нь хүргэдэг.

Хоол шим тэжээлийн доройтолтой настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг хавсралт дахь алгоритмийн дагуу үзүүлнэ.

Сувилагч, нийгмийн ажилтан ICOPE үнэлгээгээр сүүлийн 3 сарын хугацаанд аяндаа 3 кг ба түүнээс дээш жин хаясан уу? Хоолны дуршил буурсан уу? гэсэн асуумжийн хоёуланд нь “үгүй” гэж хариулсан тохиолдолд настанд эрүүл мэнд, эрүүл идэвхтэй амьдралын зөвлөгөө өгнө. Харин дээрх хоёр асуумжид хоёуланд эсвэл аль нэгэнд нь “тийм” гэж хариулсан бол эмч рүү илгээж, хоол тэжээлийн доройтлыг MNA шалгуур (Хүснэгт4)-аар лавшруулан оношилно.

Хүснэгт 4

Хоол шим тэжээлийн доройтлыг илрүүлэх асуумж- Mini Nutrition Assessment- MNA

Илрүүлэг хэсэг (А-Е асуумж)		
А.	Хоолны дуршил буурснаас, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчнөөс, зажлах, залгих хүндрэлээс болоод таны хоолны хэрэглээ сүүлийн 3 сард буурсан уу?	Хоолны хэрэглээ .. Эрс буурсан бол - 0 оноо Дунд зэргийн бууралт - 1 оноо Огт буураагүй - 2 оноо
Б.	Сүүлийн 3 сард биеийн жин хасагдсан уу?	3 кг-аас дээш жин буурсан- 0 оноо Мэдэхгүй - 1 оноо 1-ээс 3 кг жин буурсан - 2 оноо жин хасагдаагүй - 3 оноо
В.	Хөдөлгөөний байдал	Хэвтэрт эсвэл тэргэнцэр, сандалд суумгай байдаг - 0 оноо Ойр зуур босдог ч гэрээс гардаггүй - 1 оноо Гэрээс бие даан гарч чаддаг- 2 оноо
Г.	Сүүлийн 3 сарын хугацаанд цочмог өвчнөөр өвдсөн, сэтгэл зүйн стресс нөлөө байсан уу?	Тийм - 0 оноо Үгүй - 2 оноо
Д.	Мэдрэл, сэтгэцийн байдал	Тэнэгрэлтэй эсвэл ТМЧ(танин мэдэхүйн чадвар)-ын хүнд зэргийн алдагдалтай, сэтгэл гутралтай - 0 оноо ТМЧ-ийн дунд зэргийн алдагдалтай - 1 оноо мэдрэлийн сэтгэлзүйн асуудал байхгүй - 2 оноо
Е.	Биеийн жингийн индекс	19 кг/м ² -аас бага - 0 оноо 19-20 кг / м ² - 1 оноо 21-22 кг/м ² - 2 оноо 23 кг/м ² ба түүнээс дээш - 3 оноо
Илрүүлэг хэсгийн нийлбэр онооны нийлбэр: _____/14/ Тайлбар: Хэрэв нийт оноо 12-14 бол - хоол тэжээлийн байдал хэвийн .		

Хэрэв нийт оноо 12-оос бага байвал Хоол шим тэжээлийн байдлыг дэлгэрүүлж үнэлнэ үү (Ж-Т асуумж).

Ж.	Бие даан амьдардаг (гэртээ болон асрамж, сувилахуйн төв эсвэл эмнэлэгт)	үгүй - 0 оноо тийм - 1 оноо
З.	Өдөрт гурваас дээш эм хэрэглэдэг.	үгүй - 0 оноо тийм - 1 оноо
И.	Холголт, цооролтын шарх бусад арьсны шархтай эсэх	үгүй - 0 оноо тийм - 1 оноо
К.	Өвчтөн өдөрт хэдэн удаа хоолоо гүйцэд иддэг вэ?	1 удаа - 0 оноо 2 удаа - 1 оноо 3 удаа - 2 оноо
Л.	Хүнсэн дэх уургийн хэрэглээ: <ul style="list-style-type: none"> • нэг х.н сүүн бүтээгдэхүүн = 1 стакан сүү, 60 гр зуслангийн бяслаг, 30 гр бяслаг, 3/4 аяга жимсний тараг) өдөр бүр ТИЙМ/ҮГҮЙ • шош, өндгийг хоёр ба түүнээс дээш х.н-ээр долоо хоног бүр ТИЙМ/ҮГҮЙ • малын болон загас, тахианы махыг өдөр бүр ТИЙМ/ҮГҮЙ 	Хэрэв 0-1 хариулт "тийм" бол - 0 оноо Хэрэв 2 хариулт "тийм" бол - 0.5 оноо Хэрэв 2 хариулт "тийм" бол - 1 оноо
М.	Хоёр ба түүнээс дээш хүнсний нэгж жимс, хүнсний ногоог өдөр бүр хэрэглэдэг (1 х.н = 200 гр хүнсний ногоо, 1 дурын дунд хэмжээний жимс)	үгүй - 0 оноо тийм - 1 оноо
Н.	Та өдөрт хэр их шингэн уудаг вэ?	3-аас бага аяга - 0 оноо 3-5 аяга - 0.5 оноо 5-аас дээш аяга - 1 оноо
О.	Хооллоо яаж иддэг вэ?	Хэн нэгний тусламжгүйгээр идэж чадахгүй- 0 оноо Ганцаараа бага зэрэг иддэг боловч бэрхшээлтэй - 1 оноо Өөрөө хооллодог - 2 оноо
П.	Хоол тэжээлийн байдалд өгөх өөрийн үнэлгээ	өөрийгөө хоол тэжээлийн дутагдалтай гэж үнэлдэг – 0 оноо хоол тэжээлийн байдал тодорхойгүй - 1 оноо хооллолтын ямар ч асуудалгүй гэж өөрийгөө үнэлдэг - 2 оноо

Р	Таны насны бусад хүмүүстэй харьцуулахад эрүүл мэндийн байдлаа хэрхэн үнэлэх вэ?	тийм ч сайн биш - 0 оноо мэдэхгүй - 0.5 оноо адилхан сайн - 1 оноо илүү сайн - 2 оноо
С	Бугалганы дунд хэсгийн тойргийн хэмжээ	20 см ба түүнээс бага - 0 оноо 21-22 см - 0.5 оноо 23 см ба түүнээс дээш - 1 оноо
Т.	Шилбэний тойрог	31 см-ээс бага - 0 оноо 31см ба түүнээс дээш - 1 оноо

Тус илрүүлэг асуумжийн асуултын утгыг тайлбарлан ойлгуулж, ойлгож байгаа эсэх, бүрэн гүйцэд сонсож байгаа эсэхэд хяналт тавьж хариултыг авна. Шаардлагатай тохиолдолд үзүүлэн таниулах материал ашиглана. Биеийн жингийн индекс, шилбэний тойргийг хэмжиж тэмдэглэнэ. Үнэлгээгээр 24-30 оноо авсан бол **“Хоол шим тэжээлийн байдал хэвийн”**, 17-23.5 оноо авсан настанд **“Хоол шим тэжээлийн доройтол үүсэх эрсдэлтэй”** гэж үзнэ. Харин 17 ба түүнээс доош оноо авсан тохиолдолд **“Хоол шим тэжээлийн доройтолтой”** гэж үнэлнэ.

В.4.2. Хоол тэжээлийн доройтолд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

Хоол тэжээлийн доройтолд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг сувилагч, нийгмийн ажилтан тодруулна:

- Хүнд хэлбэрийн шингэн алдалт байгаа эсэх,
- Хоол шим тэжээлийн хангалтгүй хэрэглээтэй эсэх,
- Хооллож чадахгүй байгаа шалтгааныг тодруулах,
- Настны доройтолтой эсэх,
- Саркопени нь архаг үрэвсэлт өвчин, зохисгүй буруу, хангалтгүй хооллолт эсвэл хөдөлгөөний дутагдлаас үүсдэг тул асуух,
- Архаг өвчин, хүнд хэлбэрийн шингэн алдалт, хоол боловсролт шимэгдэлт алдагдах хам шинж, архаг өвдөлт, зүрх, амьсгал, бөөрний дутагдал, бөөрний архаг өвчин, чихрийн шижин хэв шинж 2, сэтгэл гутрал, тэнэгрэл, яс булчингийн тогтолцооны өвчин байгаа эсэхийг тодруулна.

В.4.3. Хоол тэжээлийн доройтлын үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

Олон улсын өвчний ангиллаар ICD10-аар E44 буюу хоол тэжээлийн доройтлыг үнэлэх MNA сорилоор **“Хоол тэжээлийн доройтолтой”** настанд хоол тэжээлийг нэмэлтээр өгөх, хоол боловсруулалтыг сайжруулах, эсийн бодисын солилцоог дэмжих эмийн эмчилгээ, хувь хүний онцлогт тохирсон эмчилгээний хоолыг хоолзүйчийн зөвлөсний дагуу даруй эхлүүлэх, хооллох, амаар уух нэмэлт тэжээлийг өгнө. Амаар уух нэмэлт тэжээл нь үл орлуулагдах амин хүчлээр баялаг уураг, хангалттай хэмжээний амин дэм, эрдэс бодис агуулсан илчлэг чанар өндөртэй тэжээл юм. Хувь хүний хэрэгцээ, амт, биеийн эрүүл мэндийн байдалд тохируулж нэмэлт тэжээлийн хэрэглэнэ. Амаар уух нэмэлт тэжээл нь хоолонд хольж хэрэглэх, хоолны хооронд найруулж уулгах г.м төрөлтэй. Хоол шим тэжээлийн байдалд үнэлгээ хийж, уургийн хэрэглээ хоногт 400-

600 ккал/өдөрт нэмэлтээр тооцож өгч, бусад шим тэжээл нөхөж, жинг тогтмол хянаж, хооллолтын байдлыг хянаж зөвлөгөө өгнө (Зураг 5).

Өөрөө хооллох боломжгүй, гуурсаар, ходоодны стомоор болон судсаар хоол тэжээл нөхөж байгаа тохиолдолд хамар, ходоодны гуурс, ходоодны стомын арчилгаа, цэвэрлэгээ, түүгээр хооллох аргыг асран хамгаалагчид зааж сургана.

“Хоол шим тэжээлийн доройтол үүсэх эрсдэлтэй” настанд шалтгааныг эмчлэхээс гадна “Гэр” зөвлөмжийн дагуу шим тэжээлээр баялаг хоолоор хооллоно. Хооллолтын байдлыг идэвхтэй дэмжин 14 хоног тутамд жин болон хооллолтын байдлыг хянаж, зөвлөгөө өгнө.

Эмийн болон хоол эмчилгээний зэрэгцээ В.4.2-т заасан эрсдэлт хүчин зүйлсийг холбогдох оношилгоо, эмчилгээний зааврын дагуу оношилж, эмчилнэ.

Хоол шим тэжээлийн доройтолд нөлөөлж буй нийгэм, хүрээлэн буй орчин нөхцөл, асран хамгаалагчийн асаргаа дэмжлэг, хооллож буй байдал, хүнсний бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамжийг сайжруулах дараах зөвлөгөөг үр хүүхэд, асран хамгаалагч нарт зааж өгнө:

- Хоол зүйчийн өгсөн хоолны зөвлөгөө, боловсруулж өгсөн хоолны цэсний дагуу цаг хугацааг баримтлан хоолыг бэлдэж, бэлдсэн хоолыг бүрэн идүүлнэ.
- Хооллох бүрт шинээр хоол бэлдэж өгнө.
- Ахмад настны идсэн хоол, уусан шингэнийг тэмдэглэж, биеийн жинд гарч буй өөрчлөлтийг тогтмол бүртгэж, холбогдох эмч сувилагч нарт мэдээлнэ.
- Амаар уух нэмэлт тэжээл зөвлөсөн бол зөвлөсөн цагт, зөвлөсөн хэмжээгээр бүрэн өгнө.
- Хооллолтыг гуурсаар болон судсаар дэмжих хэрэгцээ гарсан тохиолдолд мэргэжлийн сувилагч, хоол зүйчтэй холбогдон тогтмол зөвлөгөө авна.
- Ахмад настан гуурс, стомоор хооллож байгаа тохиолдолд гуурс, стомын арчилгаа, цэвэрлэгээний талаар асран хамгаалагчид зааж өгч, ариун цэвэр, халдвар хамгааллын дэглэм тогтмол сахиж хооллоно.

Настны эрүүл мэндийн шалтгааны улмаас хоол шим тэжээлийг хангалтгүй хэрэглэх, хооллож чадахгүй байх, амтлах, үнэрлэх мэдрэмж буурах, зажлах, залгихад хүндрэлтэй байх, нийгмийн талаас хоолоо өөрөө хийж идэж чадахгүй байх, хүнсээ цуглуулж чадахгүй байх, ганцаараа амьдрах, орлого багатай байх зэрэг нь ахмад настныг хоол тэжээлийн дутагдалд хүргэдэг. Иймээс ахмад настан хүнсний бүтээгдэхүүн авах, санхүүгээ зохицуулах, хоол хүнс бэлтгэхэд туслах, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд хамруулах талаар аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтанд холбон зуучилж олон мэргэжлийн багийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Хүнсний бүтээгдэхүүнээ худалдан авч чадахгүй, хоолоо хийж чадахгүй ахмад настанг байршуулан асрах байгууллага, цалинтай болон цалингүй асрагч бүхий олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамж үйлчилгээнд бүртгүүлэн хоол хүнсийг бэлдэж өгөх, бэлэн хоол хүргэж өгдөг эрх бүхий байгууллагад холбон зуучилна.

В.4.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

- Ахмад настанд зажлах, залгих, хавсарсан архаг өвчний шалтгаант хоол шим тэжээлийн доройтол илэрч байгаа үед хоолзүйчид илгээнэ.
- Амаар 3 хоногийн дотор хангалттай хэмжээний хоол идээгүй ахмад настанг шалтгааныг тодруулахаар илгээнэ.
- Хүнд зэргийн тураалын үед амаар хооллох боломжгүй болсон ахмад настанг мэс заслын эмчид илгээнэ.

В.5 ХАРААНЫ БЭРХШЭЭЛИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

В.5.1. ICOPE үнэлгээний харааны бэрхшээлийг лавшруулан оношлох алгоритм

Харах чадвар нь ахмад настанд идэвхтэй хөдөлгөөнтэй байх, нийгэм, орчиндоо аюулгүй харьцах боломжийг олгодог тэдний эрүүл мэндийг тодорхойлох гол бүрэлдэхүүн хэсэг юм. Нас дагаж ойрын болон алсын хараа муудах төдийгүй болор цайх, нүдний даралт ихсэх, шар толбоны сөнөрөл г.м нүдний бие даасан өвчин үүсдэг. Эдгээр бие даасан өвчин эмгэгийг холбогдох оношилгоо, эмчилгээний зааврын дагуу эмчилнэ.

Харааны бэрхшээл нь ахмад настанг идэвхтэй хөдөлгөөнтэй байх, нийгэм, орчиндоо аюулгүй харьцах, гэр бүл болон нийгмийн харилцааг хадгалах, мэдээлэл олж авах, зааварчилгааг биелүүлж чадахгүйд хүргэдэг тул настны сэтгэл түгшилт, сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлдөг.

Харааны бэрхшээлтэй ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг алгоритмийн дагуу үзүүлнэ.

Сувилагч, нийгмийн ажилтан харааны бэрхшээлийг илрүүлэхдээ дараах ICOPE асуумжаар дараах асуултыг асууж үнэлнэ. Үүнд:

- Танд хол ойрын зүйл харахад бэрхшээл тулгардаг уу? Нүдний хараанд нөлөөлөх нүдний өвчин, чихрийн шижин, артерийн даралт ихсэлт г.м архаг өвчин байдаг уу? гэсэн асуултад хоёуланд нь “үгүй” гэж хариулсан тохиолдолд **“Харааны бэршээлгүй”** гэж үнэлнэ.
- Дээрх асуултанд хоёуланд нь эсхүл аль нэгэнд нь “тийм” гэж хариулсан тохиолдолд **“Харааны бэрхшээлтэй”** гэж үзэн холын болон ойрын харах чадварыг тодорхойлох сорилоор лавшруулан оношилно.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд харааны чадал шалгах энгийн үнэлгээг хийнэ. Үүнд:

Холын харах чадлыг шалгахын тулд ойрын харааны чадал шалгахаас өмнө харааны хүснэгтийг үйлчлүүлэгчийг суулгаснаас цэгээс 3 метрийн зайд байрлуулна. Харааны шилтэй хүний харааг шилгүй шалгах, хоёр нүдээр зэрэг шалгахаас өмнө нүд тус бүрийг ээлжилж шалгана.

Харааны чадлыг хэмжих E сорилыг хэрхэн хийж гүйцэтгэхийг хэлж тайлбарлана. Харааны чадлыг шалгахдаа баруун нүдний, зүүн нүдний, 2 нүдний буюу хос харааны чадал гэж тодорхойлно.

Холын харааны алдагдал:

- Холын харааны алдагдал хөнгөн– Харааны чадал 6/12-аас бага байх
- Холын харааны алдагдал дунд– Харааны чадал 6/18-аас бага байх
- Холын харааны алдагдал хүнд– Харааны чадал 6/60-аас бага байх
- Холын харааны алдагдал маш хүнд буюу хараагүй– Харааны чадал 3/60-с бага байх.

Холын хараа шалгах дөрвөн том E оптотип

M



Том E оптоотипийн хэмжээ нь 4.2 см х 4.2 см байх ба өөр хоорондын зай 4.5 см байна. Энгийн цагаан цаасан дээр хэвлэсэн цулгуй хар E оптотип байна.

E



3 метрийн зайнаас том E оптотипээр шалгаж, E оптоотипийг харж чадаж байвал харааны чадлыг 6/60 гэж үнэлнэ.

S



Хэрэв 3 метрийн зайнаас том гурван E оптоотипийг харахгүй байвал 1.5 метрийн зайнаас том E оптоотипээр шалгана. Хэрэв дөрвөн том E оптоотипээс гурвыг харж байвал харааны чадлыг 3/60 гэж үнэлнэ.

E



Холын хараа шалгах дөрвөн жижиг E оптотип)

M



Жижиг E оптоотипийн хэмжээ нь 1.3 см х 1.3 см байх ба өөр хоорондын зай 1.3 см байна. Энгийн цагаан цаасан дээр хэвлэсэн цулгуй хар E оптотип байна.

E



Дөрвөн жижиг E оптоотипийн байрлалыг тодорхойлж үнэлгээг хийнэ. Дөрвөн E оптоотипоос дор хаяж 3-ых нь чиглэлийг зөв зааж байвал алсын хараа 6/18 буюу сайн байна.

S



Хэрэв багадаа гурвыг харж чадахгүй бол харааны бэрхшээлтэй гэж үнэлээд, нүдний өвчний нэмэлт үнэлгээг хийнэ.

E



Ш Э Е Ш

Ойрын хараар шалгах хүснэгт

Е Ш Э М
м е ш

Ойрын харах чадварыг шалгахдаа ойрын харах чадварыг тодорхойлох хүснэгтийг ашиглана. Хамгийн томоос хамгийн жижиг E оптотип хүртэл чиглэлийг тодорхойлон хэлж сорилыг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ.

1. Тухайн хүний өөрийн хүссэн зайд том E оптоотипээс жижиг E оптоотип хүртэл ойрын харааг шалгах,
2. Хэрэв дөрвөн том E оптоотипээс гурвыг харж, чиглэлийг нь зөв хэлж байвал ойрын харааны чадал "Хангалттай" гэж тооцох,
3. Хэрэв үгүй бол дөрвөн том E оптоотипээс хамгийн багадаа гурвыг харж чадахгүй бол "Үнэлэх боломжгүй" гэж тооцон нүдний нарийн оношилгоо шинжилгээнд хамрагдахыг зөвлөнө.

Дунд хэмжээтэй оптоотип нь номын үсэгтэй ойролцоо байдаг бол жижиг хэмжээтэй оптоотип нь ном, сэтгүүлийн хамгийн жижиг үсэгтэй тэнцүү ба үүнийг заавал унших шаардлагагүй.

В.5.2. Харааны бэрхшээлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

Харааны бэрхшээлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг сувилагч, нийгмийн ажилтан тодруулна:

- Артерийн даралт ихсэлт нь нүдний торлогийн өвчин, нүдний даралт ихсэхэд, чихрийн шижин хэв шинж 2 өвчнөөр өвдсөн эсэх,
- Дааврын эмийн их хэрэглээтэй эсэх,
- Хувийн ариун цэвэр сахихгүй байх: бохир гараар нүдэнд хүрэх, нухах, зовхи нүдийг цочроох будаг, саван хэрэглэсэн эсэх,
- Эрүүл ахуйн шаардлага хангахгүй гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэсэн эсэх, сормуус хийлгэх, контур шивүүлсэн эсэх.

В.5.3. Харааны бэрхшээлийн үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

Настан болор цайх, нүдний даралт ихсэх, шар толбоны сөнөрөл г.м нүдний өвчин, эмгэгтэй бол холбогдох оношилгоо, эмчилгээний зааврын дагуу эмчилнэ.

Харааны бэрхшээлд хүргэдэг эрсдэлт хүчин зүйлс нь хараа муудах, харааны мэдрэлийг гэмтээх улмаар сохролд хүргэх аюултай тул эрсдэлт хүчин зүйлсийг эмчлэх, түүнээс сэргийлэх талаар зөвлөнө.

Харааны бэрхшээлийг гүнзгийрүүлэхгүйн тулд дараах эмчилгээ, зөвлөгөө өгнө:

- ✓ Харах чадварыг хадгалах, сайжруулахын тулд хараагаа жилд 1 удаа үзүүлэх,
- ✓ Хэрэв боломжтой бол 50 болон түүнээс дээш насны иргэд хамгийн багадаа жилд нэг удаа нарийн мэргэжлийн нүдний эмчийн үзлэгт хамрагдах,
- ✓ Харах эрхтний ортопед тусгай хэрэгсэл худалдан авах, үнийн хөнгөлөлт эдлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтанд холбон зуучилж өгнө.
- ✓ Өөрт тохирсон шилийг тогтмол зүүх, арчлах талаар зөвлөх,
- ✓ Гар утас, компьютер, телевизорыг удаан хугацаагаар үзэхгүй байх, тэдгээрийн дэлгэц нь нэг төрлийн дэвсгэр өнгөнөөс тод ялгарах том үг үсэгтэй байх, мөн гар утас, компьютерийн программыг ярьдаг хэлбэрээр тохируулж өгөх,

- ✓ Өдөр тутмын үйл ажиллагаандаа сонсдог хэрэгслийг ашиглаж сурахыг зөвлөнө. Үүнд: ярьдаг цаг, халуун хэмжигч, жин гэх мэт.
- ✓ Гэрэлтүүлэг муутай нөхцөлд ном уншихгүй байх,
- ✓ Зарим тохиолдолд ойрын харааны шил нь хангалттай сайн томруулж харагдуулдаггүй тул ширээний болон зөөврийн томруулагч шилийг ном, сонин унших, мөнгө ялгах, тоолох, шошго унших, юм оёхдоо ашиглахыг зөвлөх,
- ✓ Сэргээн засах боломжгүй хараа муутай настанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, орон зайн чиг баримжаа олгох, орчиндоо аюулгүй алхах техник эзэмшүүлэх, өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд зааж сургах,
- ✓ Харааны бэрхшээл үүсэх, нүд өвдөхөд хувь хүний ариун цэвэр сахих нь чухал ач холбогдолтой. Иймд гараа тогтмол савандаж угаах, бохир гараар нүдээ нухахгүй байх, зовхи нүд цочроох гоо сайхны бүтээгдэхүүн, саван хэрэглэхгүй байх, сормуус хийлгэх, наах, контур шивүүлэхгүй байх,
- ✓ Гэрийн дотоод болон гадаад орчныг ээлтэй болгох дараах зөвлөгөөг өгнө.
 - Гэрийн доторх байгалийн болон зохиомол гэрэлтүүлгийг нүд гялбахгүйгээр, сүүдэрлэхгүйгээр тохируулан байршуулах,
 - Орны дэргэд ширээний гэрэл байрлуулах,
 - Гэрлийн унтраалгыг орны ойр, гар хүрэх газарт байрлуулах,
 - Тэдний явах замыг саадгүй болгохын хөлд тээглэх зүйлийг зайлуулах,
 - Настны тогтмол хэрэглэдэг эд зүйлсийг тодорхой нэг газар байрлуулах,
 - Явах газрын түвшин дээшилсэн, доошилсон хэсэгт ялгах тод өнгийн тэмдэглэгээ хийх,
 - Шат, гэрийн босго, довжооны ирмэг дээр ялгах тодосгогчтой тэмдэглэгээ хийх,
 - Гэр ахуйн болон гал тогооны хэрэгслийн бариулыг тод ялгарч харагдахуйц өнгөөр будах,

В.5.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт:

- Хэрэв ахмад настан нүдний өвчнөөр өвчилсөн эсвэл нүдний өвчин нь оношлогдсон, нэг юм уу хоёр нүдний харааны чадвар огцом буурсан тохиолдолд,
- Артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин хэв шинж 2 өвчтэй бол жилд 1 удаа,
- Дааврын эмийн эмчилгээг 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар эмчилгээ хийлгэсэн тохиолдолд тус тус илгээнэ.

В.6. СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

В.6.1. ICOPЕ үнэлгээний сонсголын бэрхшээлийг лавшруулан оношлох алгоритм

Сонсголын бэрхшээлтэй байх нь нийгмийн бүхий л харилцаанд саад болж, өөрийгөө бүрэн тусгаарлагддаг ба танин мэдэхүйн бууралт, тэнэгрэл, сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, тэнцвэр алдагдал, явганаас унах бэртэх эрсдэлд хүргэдэг. Сонсголын бэрхшээлтэй ахмад настанд тусламж үзүүлэхдээ алгоритмийн дагуу тусламж үзүүлнэ.

Сонсголын бэрхшээлийг шивнээ ярианы сорил, аудиометрийн шинжилгээгээр үнэлэх ба хоёр сорилын аль нэгийг нь ашиглаж болно.

Шивнээ ярианы сорил нь тухайн хүний сонсгол хэвийн эсэхийг шалгана. Сувилагч, нийгмийн ажилтан сонсголын бэрхшээлийг шивнээ ярианы сорилыг дараах дэс дарааллаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- ✓ Тухайн ахмад настны ар болон хажуу талаас нэг гарын урттай /50 см/ зайд зогсоно.
- ✓ Тухайн ахмад настан эсвэл хажууд байгаа хэн нэгнээр туслуулж сонсголын гадна сувгийг хаах зорилгоор чихний урд хэсэгт зөөлөн дарна.
- ✓ Сорил авагч амьсгалаа аваад дараа нь утга хамааралгүй, дуудлага адил сонсогдохгүй дөрвөн үгийг зөөлөн шивнэнэ.
- ✓ Тухайн настнаас хэлсэн 4 үгээ давтахыг хүснэ. Зарим үед 4 үгийг нэг нэгээр нь цувуулж хэлүүлнэ.
- ✓ Хэрэв 3-аас дээш үг зөв хэлбэл тэр талын чихний сонсгол хэвийн гэж тодорхойлно.
- ✓ Сонсголыг хоёр талын чихэнд тус тусад нь тодорхойлно.

Дээрх сонсголын сорилоор хэвийн сонссон ахмад настанг “сонсголын бэрхшээлгүй” гэж тодорхойлоод сонсгол хамгаалах, чих арчлах болон эрүүл амьдралын хэв маягийн талаарх зөвлөгөөг сувилагч, нийгмийн ажилтан өгнө.

Шивнээ ярианы сорилыг гүйцэтгэж чадаагүй, сонсгол буурсан гэж өгүүлэмжтэй ахмад настанд аудиометрийн шинэжилгээ хийлгүүлэн сонсголын бууралтын түвшинг тодорхойлуулна.

В.6.2. Сонсголын бэрхшээлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

Аудиометрийн сорилоор дунд ба хүнд зэргээр сонсгол буурсан ахмад настны сонсгол бууралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг сувилагч, нийгмийн ажилтан асууж тодруулна. Үүнд:

- Чих арчилгааны эрүүл ахуйн дэглэм алдагдсан эсэх,
- Байнгын дуу чимээ ихтэй газар байдаг эсэх,
- Ототоксик эм буюу стрептомицин, гентамицин зэрэг антибиотууд, хинин, хумхаагийн эсрэг эм, хлорохин гэх мэт эмийг байнга хэрэглэдэг эсэх,
- Чихний өвдөлт, булаг гардаг эсэх,
- Гэнэт сонсгол буурсан эсэх,
- Толгой эргэдэг эсэх,
- Дунд чихний архаг үрэвслээр өвдөж байсан эсэх.

В.6.3. Сонсголын бэрхшээлийн үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

Сонсгол бууралтыг гүнзгийрүүлэхгүйн тулд дараах зөвлөгөөг өгнө. Үүнд:

- ✓ Сонсголын аппарат тааруулуулах, тогтмол зүүх, арчлах талаар зааж сургах,
- ✓ Сонсголын аппарат худалдан авах, үнийн хөнгөлөлт эдлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтанд холбон зуучлах,
- ✓ Чихийг хуурайгаар ухаж авч болохгүй бөгөөд хулхи дэвтсэн тохиолдолд чих ухдаг цэвэрлэх зориулалтын багаж ашиглан зөөлөн цэвэрлэх,

- ✓ Чихэндээ хүрэхдээ гараа тогтмол угааж, хувь хүний ариун цэврээ сахих, бохир хуруугаар чихээ ухах, чихэндээ энгийн үед халуун эсвэл хүйтэн тос, ургамлын гаралтай эм дусаахгүй байх,
- ✓ Сонсголд нөлөөлдөг эмийн хэрэглээг багасгах, хянах,
- ✓ Чихний архаг хууч өвчний сэдрэлийг бүрэн эмчлэх, эмчийн хяналтад байнга байх,
- ✓ Чимээ шуугиан багатай орчинд байх,
- ✓ Чихэвчээр тогтмол юм сонсохгүй байх,
- ✓ Шаардлагатай тохиолдолд сонсгол судлаач эмчид үзүүлж, зөвлөгөө авах.

Сонсгол бууралттай настны гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, найз нөхдөд нь ахмад настантай харилцах дараах харилцааны арга эзэмшүүлнэ:

- ✓ Аль болох сайн сонсдог чихэн талд нь, нэг түвшинд нүүр нүүрээ харан, уруулын хөдөлгөөн унших боломжтой зайнаас харьцах,
- ✓ Жигд тод өнгөөр хашгиралгүй ярилцах, ярилцахын өмнө анхаарлыг татах,
- ✓ Амьдрах орчинд нь хаалганы хонх, утасны дууг тод сонсогдохуйц байдлаар байрлуулах,
- ✓ Настанг нийгэм хамт олны дунд олон нийтийн ажилд оролцуулахыг зөвлөх, ингэснээр танин мэдэхүйн бууралт, сэтгэл гутрал болон сонсгол бууралтаас үүдэлтэй бусад сөрөг сэтгэл хөдлөл, зан үйлийн үр дагаврыг бууруулна.

Сонсголын аппарат хэрэглэж хэвшүүлнэ:

- ✓ Аудиометрийн сорилоор "сонсголын бууралттай" гэж оношлогдсон настанд тохирох сонсголын аппаратыг санал болгох,
- ✓ Сонсголын аппараттай болмогц эрүүл мэндийн ажилтан түүний тогтмол хэрэглээг дэмжин, урамшуулж, байнга хэрэглэн хэвшүүлэх хэрэгтэйг ахмад настанд ойлгуулах,
- ✓ Сонсголын аппаратыг хаяж гээгдүүлэх, мартахаас сэргийлж бэхлэх аргыг зааж өгөх.

Чихний дунгийн суулгац нь сонсголын аппаратаар засагдах боломжгүй сонсголын хүнд зэргийн бэрхшээлтэй хүнд тохиромжтой. Чихний дунгийн суулгацыг мэс заслын аргаар хийдэг. Энэ нь дуу чимээг цахилгаан импульс болгон хувиргаж, чихний мэдрэл рүү илгээдэг. Чихний дунгийн суулгацийн хэрэгцээг тодорхойлохын тулд ахмад настанг сайтар үнэлэх ёстой. Хэрэв дунгийн суулгац хийх боломжгүй бол ахмад настан болон түүний гэр бүлийнхэнд уруул унших, бичих, дохионы хэлээр ярилцах аргад сургана.

Сонсгол буурахад нийгмийн болон амьдарч буй орчны нөлөө их байдаг. Сонсгол бэрхшээл нь сэтгэл гутрал, нийгмийн тусгаарлалтад ихэвчлэн хүргэдэг. Иймээс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтанд холбон зуучилна.

В.6.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт:

- Сонсголын бэрхшээлтэй настны сонсох чадварын түвшинг тодорхойлуулах,
- Сонсголын аппарат сонгуулах, тохируулах,
- Чихний цочмог, архаг өвчнийг оношлуулах, эмчлүүлэх.

В.7. СЭТГЭЛ ГУТРАЛЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

В.7.1.ICOPE үнэлгээний сэтгэл гутралыг лавшруулан оношлох алгоритм

Сэтгэл гутрал нь бие даах чадвараа удаан хугацаанд алдсан, нийгмээс тусгаарлагдсан, бусдын асаргаанд байдаг ахмад настанд ихэнхдээ тохиолддог.

Сэтгэл гутралтай ахмад настанд алгоритмийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

Сэтгэл гутралыг илрүүлэх ICOPE илрүүлэг асуумж буюу Хүснэгт 1-ийн дагуу сувилагч, нийгмийн ажилтан үнэлнэ. Үнэлэхдээ сүүлийн 2 долоо хоногийн турш сэтгэлээр унаж, гуниглан илтгэл найдвараа алдаж байсан уу?, Аливаа зүйлийг хийх идэвх, сонирхол буурч байсан уу? гэсэн 2 асуултыг асууна. Дээрх хоёр асуултад хоёуланд нь “үгүй” гэж хариулсан ахмад настанд **“Сэтгэл гутралгүй”** гэж оношилно.

Харин 2 асуултанд аль нэгэнд эсвэл хоёуланд нь **“тийм”** гэж хариулсан ахмад настанд **“Сэтгэл гутрах эрсдэлтэй”** гэж үзэн эмчид үзүүлж, настны сэтгэл гутралыг GDS (Geriatric Depression Scale-GDS) асуумжаар (Хүснэгт 5) лавшруулан үнэлнэ.

Хүснэгт 5

Настны сэтгэл гутралыг үнэлэх (GDS) илрүүлгийн асуумж

№	Сэтгэл гутралыг илрүүлэх асуумж	Тийм	Үгүй
1	Та амьдралдаа сэтгэл хангалуун байна уу?	Тийм	Үгүй
2	Та ихэвчлэн гунигтай байдаг уу?	Тийм	Үгүй
3	Та өөрийгөө арчаагүй дорой мэт боддог уу?	Тийм	Үгүй
4	Та гадуур гарч шинэ зүйл хийхээс илүү гэртээ байхыг илүүд үздэг үү?	Тийм	Үгүй
5	Та өөрийгөө хэрэгцээгүй хүн гэж бодож байна уу?	Тийм	Үгүй
Нийт оноо =			

Тус GDS асуумжаар настанг үнэлэхдээ асуултыг настан сонсож, ойлгож байгааг шалгаж, настанд өөрийгөө танилцуулж, үнэлгээний талаар тайлбарлана. Асуумжийн доогуур зурсан хариулт болгонд 1 оноо өгнө. Үнэлгээ нийт 5 оноотой. 2 оноо авсан тохиолдолд **“Сэтгэл гутралгүй”**, 2 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд **“Сэтгэл гутралтай”** гэж сувилагч, нийгмийн ажилтан үнэлнэ.

Сэтгэл гутралтай гэж үнэлэгдсэн настны айдас түгшүүр, сэтгэл гутралыг түвшинг HADS (Hospital anxiety and depression scale -Хүснэгт 6) асуумжаар эмч лавшруулан оношилно.

Хүснэгт 6.

Айдас түгшүүр, сэтгэл гутралыг түвшинг үнэлэх (HADS) илрүүлгийн асуумж

1	Миний сэтгэл нэг л эвгүй, түгшүүртэй мэт санагддаг.		8	Би бүх л зүйлийг удаан хийгээд, нозоороод байх шиг санагддаг.	
A	3	Цаг үргэлж	D	3	Үргэлж
	2	Ихэнх цагт		2	Ойр ойрхон давтамжтай
	1	Хааяа нэг		1	Заримдаа
	0	Огт үгүй		0	Огт үгүй
2	Надад өмнө нь таалагддаг зүйлс одоо ч гэсэн таалагддаг.		9	Сандарч түгшсэн үед дотор зарсхийх мэдрэмж төрдөг	
D	0	Мэдээж их	A	0	Огт үгүй
	1	Тийм ч их биш		1	Хааяа нэг
	2	Ховорхон		2	Нилээд их
	3	Огт үгүй		3	Маш их
3	Ямар нэг аймшигтай муу зүйл болох гэж байгаа юм шиг мэдрэмж төрснөөс болж би айж түгшдэг.		10	Би өөрийн гадаад үзэмжиндээ анхаарал тавихаа болсон.	
A	3	Яг үнэн ба маш их эмээж байна	D	3	Яг үнэн, анхаарал тавихаа болсон
	2	Тийм, гэвч тийм ч муугаар биш		2	Би өөртөө анхаарал тавих нь нилээд буурсан
	1	Бага зэрэг, гэвч санаа зовох хэмжээнд биш		1	Би өөртөө анхаарал тавих нь буурсан байж магадгүй
	0	Огт үгүй		0	Би өөртөө ердийнх шигээ анхаарал тавьж байгаа
4	Би аливаа зүйлсийн хөгжилтэй талыг нь олж харан, инээж чаддаг.		11	Би тайван сууж чадахгүй үргэлж холхиод (нааш цааш холхиод) баймаар санагдах болсон.	
D	0	Чадах хэмжээндээ үргэлж инээдэг	A	3	Маш их
	1	Одоо тийм ч их инээхээ больсон		2	Нилээд их
	2	Ер нь нээх их инээхээ больсон		1	Хааяа нэг
	3	Огт инээдэггүй		0	Огт үгүй
5	Миний толгойд санаа зовоосон таагүй бодлууд эргэлдэж байдаг		12	Миний сонирхдог зүйлс надад таатай байдлыг төрүүлж урам зориг өгдөг хэвээрээ байгаа.	
A	3	Үргэлж	D	0	Өмнөх шигээ одоо ч тэсэн ядан хүлээдэг
	2	Ихэнхдээ		1	Өмнөхөөсөө бага зэрэг буурсан
	1	Заримдаа, гэхдээ тийм ч олон		2	Өмнөхөөсөө илт буурсан

		биш		
	0	Хааяа нэг		3 Огт таашаал өгөхөө байсан
6	Би баяр хөөртэй, сэргэлэн цовоо байдаг		13	Би гэнэт сандарч балмагддаг
D	3	Огт үгүй	A	3 Цаг үргэлж
	2	Хааяа		2 Ихэнхдээ
	1	Заримдаа		1 Хааяа нэг
	0	Ихэнхдээ		0 Огт үгүй
7	Би биеэ барихгүй тайван суугаад амарч чаддаг		14	Би зурагт болон фм, радиогийн сайхан нэвтрүүлэг сонсох эсвэл гоё номноос таашаал авч чаддаг
A	0	Яг үнэн	D	0 Ихэнхдээ
	1	Ихэнхдээ		1 Заримдаа
	2	Хааяа		2 Хааяа нэг
	3	Огт үгүй		3 Маш ховор

Дээрх айдас түгшүүр, сэтгэл гутралын түвшинг үнэлэхдээ асуултыг настан сонсож, ойлгож байгааг шалгаж, настанд өөрийгөө танилцуулж, үнэлгээний талаар тайлбарлана. Тус суумжаар 8 ба түүнээс доош оноо авсан бол **“Айдас түгшүүр, сэтгэл гутралын хөнгөн зэрэг”**, 8-аас дээш оноо авсан настанг **“Сэтгэл гутралтай”** гэж үзнэ.

В.7.2.Сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

Сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлж буй дараах эрсдэлт хүчин зүйлсийг сувилагч, нийгмийн ажилтан асууж тодруулна:

- Танин мэдэхүйн чадварын бууралттай эсэх,
- Сонсгол болон харааны бэрхшээлтэй эсэх,
- Өвчний улмаас тахир дутуу болсон эсэх,
- Олон эмийн хэрэглээтэй эсэх,
- Цус багадалттай эсэх,
- Хоол шим тэжээлийн доройтолтой эсэх,
- Гипотриоз оношлогдсон эсэх,
- Архаг өвдөлттэй эсэх,
- Сүүлийн зургаан сарын дотор уй гашуу тохиолдсон эсэх,
- Сэтгэцийн өвчин зэргийг асууж тодруулна.

Сэтгэл гутралд хүргэж байгаа эрсдэлт хүчин зүйл болох танин мэдэхүйн бууралт (В.2.), хараа (В.5.), сонсголын бэрхшээлтэй (В.6.) ахмад настанд холбогдох цогц тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

В.7.3. Сэтгэл гутралын үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

Олон улсын өвчний ангилал (ICD10) F06- сэтгэл гутрах өвчтэй, айдас түгшүүр, сэтгэл гутралыг үнэлэх (HADS) илрүүлгийн асуумжаар 8-аас дээш оноо авсан ахмад настанд анхан болон үндсэн тусламж үйлчилгээний эмч, эмнэлгийн мэргэжилтэн ДЭМБ-аас гаргасан mhGAP (сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчигээний заавар) зааврын дагуу оношилгоо, эмчилгээ хийнэ.

“Сэтгэл гутралгүй” гэж оношлогдсон настанд эрүүл амьдралын хэв маяг, шинэ найз нөхөдтэй болох, найз нөхөдтэйгөө хамт цагийг өнгөрөөх, үр хүүхэдтэйгээ тогтмол уулзах, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын ажил хийх, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, ижил сонирхолтой бүлэгт элсэн шинэ зүйл сурч мэдэх талаар зөвлөгөө өгөхөөс гадна гадна сэтгэл гутралын шинж тэмдгийн талаар мэдээлэл өгч, шинж тэмдэг илэрвэл эмчид хандахыг зөвлөнө.

“Айдас түгшүүр, сэтгэл гутралын хөнгөн зэрэг”-тэй настанг нийгэм хамт олонд тулгуурласан сэргээн засах тусламж, үйлчилгээнд хамруулахаар холбогдох байгууллагын нийгмийн ажилтантай холбон зуучилна.

Сэтгэлийн гутрал даамжран гүнзгийрэхээс сэргийлэх, түүнд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад дараах тусламж, үйлчилгээг үзүүлнэ:

- ✓ Төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөсөн эмийг зөв цагт, зөв тунгаар, зөв ууж байгаа эсэхэд хяналт тавих,
- ✓ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах талаар холбон зуучлах,
- ✓ Олон төрөлтөт багц дасгалыг хийлгэх,
- ✓ Анхаарал төвлөрөлтийг дэмжих амьсгалын дасгалыг хийхдээ чимээгүй орчинд сууж болон хэвтэж, амьсгал авах гаргах дээр анхаарлаа төвлөрүүлнэ. Жишээлбэл, йог хийхдээ амьсгалаа удирдах, алхах үед биеийн хөдөлгөөнийг анхаарч мэдрэхэд анхаарлаа төвлөрүүлэхийг зөвлөх,
- ✓ Бие махбодын өвчин, гэмтлийн улмаас тахир дутуу болж бие даах чадвараа алдаж, өвчтөн хүлээн зөвшөөрч чадахгүй сэтгэлзүйн хямралтай настанд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ үзүүлэх,
- ✓ Төв мэдрэлийн тогтолцоонд голчлон нөлөөлдөг антигистамин, антипсихотик, булчин сулруулах, антихолинергик, сэтгэцэд нөлөөт эмийг эмчийн хяналт, зааврын дагуу хэрэглэх, эмчийн заалтгүй эмийг хасах, хасах шийдвэр гаргаж чадахгүй байвал сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмчээс зөвлөгөө авах,
- ✓ Цус багадалтыг эмчлэх, хоол тэжээлийн доройтлыг бууруулах тусламж үйлчилгээг зааврын дагуу үзүүлэх,
- ✓ Архаг өвдөлттэй ахмад настны өвдөлтийн зэргийг үнэлж, түүний шалтгааныг илрүүлэн, өвдөлтийг намдаан эмчлэх,
- ✓ Сүүлийн зургаан сарын дотор тохиолдсон уй гашуу, аливаа зүйлд сэтгэл дундуур болох, ганцаардах, тусгаарлагдах байдлаас сэргийлж олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөтөлбөрт хамруулах, урам зориг өгөх, дэмжлэг үзүүлэх талаар гэр бүлийн гишүүд болон асран хамгаалагч нарт заавар зөвлөгөө өгөх.

В.7.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

- Сэтгэл гутралын шинж тэмдэг тод илэрсэн,
- Амиа хорлох сэдэлтэй буюу үйлдэл хийсэн,
- Бамбайн анхдагч дутагдал өвчний шинж тэмдэгтэй үед илгээнэ.

В.8. НАСТНЫ НИЙГМИЙН БАЙДАЛ, ХАЛАМЖИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

В.8.1 Настны нийгмийн байдал, халамжийн хэрэгцээг үнэлэх алгоритм

Настны цогц тусламж, үйлчилгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн байдал, нийгмийн халамж, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох явдал юм. Түүний хэрэгцээг тодорхойлохдоо:

- Нийгмийн байдлыг хураангуй асуумжаар (Хүснэгт 7),
- Бие даах чадварыг КАТЗын үнэлгээгээр (Хүснэгт 8),
- Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааг Лавтоны асуумж (Хүснэгт 9)-аар тус тус үнэлнэ.

Хэрвээ дээрх үнэлгээгээр бие даах чадваргүй, ганц бие амьдардаг, асран халамжлал хэрэгцээтэй ахмад настанд асран хамгаалагчийн ачааллыг үнэлэх Заритын аргачлал (Хүснэгт 10), нийгмийн тусламж, үйлчилгээ хэрэгцээтэй настны эрсдэлийг "Доройтлын эмнэлзүйн үнэлгээ"(Хүснэгт 11)-ээр тус тус лавшруулан оношилно.

Б.8.1.1 Олон мэргэжлийн болон хамтарсан баг, кейс менежерийн үзүүлэх шаардлагатай нийгмийн халамж, дэмжлэг, тусламж, үйлчилгээг "Настны нийгмийн байдлыг тодорхойлох хураангуй асуумж"-аар тодорхойлно.

Хүснэгт 7

Настны нийгмийн байдлыг тодорхойлох хураангуй асуумж

Настны эрүүл мэндийн асуудлууд
Гэр бүлийн байдал: гэрлэсэн/ бэлбэсэн/салсан/ тусдаа амьдардаг/ганц бие
Хүүхэд: хүү..... охин.....
Хэнтэйгээ амьдардаг вэ? Ганц бие/ гэр бүлийн хүн/хүү/ охин/найз Асрамжийн газар.....
Гэр орон:орон сууц/гэр/байшин/нийтийн байр/ Орон сууцанд бол хэддүгээр давхарт..... Түрээслэдэг эсэх/тийм/үгүй/..... Нэмэлт хэрэгсэл.....
Бие засах газар:орон сууцны, гэр хорооллын/ суултуур бүхий, суултуургүй/
Асран хамгаалагч:Гэр бүлийн хүн/хүү/охин/найз/ бусад

"Настны нийгмийн байдлыг үнэлэх" хураангуй асуумжид ганц бие, харж асрах хүнгүй ч өдөр тутмын бие даах чадвар хэвийн, хадгалагдсан ахмад настанд харъяа нутаг дэвсгэрийн нийгмийн ажилтан, халамжийн ажилтан, хэсгийн ахлагч, хороо болон багийн дарга, эрүүл мэндийн ажилтан, сайн дурын ажилтан, хувь хүн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

В.8.1.2 Настны бие даах чадвар болох хооллох, хувцаслах, усанд орох, хөдөлгөөн, бие засах, өтгөн шингэнээ барих чадварыг КАТЗ-ийн үнэлгээ (Хүснэгт 8)-ээр тодорхойлно.

Хүснэгт 8

Бие даах чадварыг КАТЗ-ийн үнэлгээ

Чадвар	Үнэлэх шалгуур	Оноо
Хооллох	Тусламжгүйгээр хооллоно	2
	Талх зүсэх, цөцгийн тос түрхэх зэрэгт тусламж шаардана	1
	Хооллоход бүрэн тусламж шаардана	0
Хувцаслах	Хувцас сонгох, өмсөхөд тусламж шаардахгүй	2
	Үдээс үдэх, товч товчлох зэрэгт тусламж шаардана	1
	Хувцаслахад туслалцаа шаардана, бүрэн хувцаслаж чадахгүй	0
Усанд орох/ ванн, шүршүүр/	Усанд тусламжгүйгээр орно	2
	Биеийн нэг хэсэг/ нуруу/ угаахад тусламж шаардана.	1
	Биеийн 2 хэсгээс дээш хэсгийг угаахад тусламж шаардана, усанд бие дааж орж чадахгүй	0
Хөдөлгөөн	Гэр дотуур болон гадагш чөлөөтэй явж чадна /таяг, түшлэгтэй байж болно/	2
	Хүний тусламж шаардан гэр дотуур явна	1
	Тусламжгүйгээр орноос босч чадахгүй	0
Бие засах	Тусламжгүйгээр ариун цэврийн өрөө рүү ганцаараа явж, суултуурт суух, ариун цэврийн цаас ашиглан цэвэрлэж чадна.	2
	Ариун цэврийн өрөө рүү ороход тусламж шаардана, хөтөвч тогтмол ашиглана.	1
	Өтгөн, шингэнээ барьж чадахгүй	0
Өтгөн шингэнээ барих чадвар	Шээс болон өтгөнөө барих чадвар сайн, өтгөн шингэнээ өөрөө хянана.	2
	Шээс, өтгөнөө гаргахад бургуй ба шээлгүүр ашиглана. Хөтөвч тогтмол хэрэглэнэ.	1
	Байнгын бургуй ба колостомийн тусламжтайгаар гаргана.	0
Нийт оноо		12

Бие даах чадварыг КАТЗ-ийн үнэлгээг тайлбарлан, ойлгуулах, асуултыг настан сонсож ойлгож байгааг шалгаж, настанг үнэлгээнд хамруулна. **КАТЗ-ийн үнэлгээгээр 0-5 оноо авсан бол “бие даах чадвар бүрэн алдагдсан-асран хамгаалагч зайлшгүй хэрэгцээтэй”** гэж үзэж, сувилагч “0” оноо авсан чадвар бүрийг дахин үнэлнэ. 6-9 оноо авсан бол “бие даах чадвар алдагдсан”, 10-12 оноо авсан тохиолдолд “бие даах чадвар хэвийн, өөрийгөө асрах чадвартай” гэж үнэлнэ.

В.8.1.3. Настанг бие даан амьдруулах, нийгмийн амьдралд оролцуулахын тулд хоолоо хийх, хувцсаа угаах, гэрээ цэвэрлэх, гадуур явах, эмээ зааврын дагуу уух, утсаар ярих, санхүүгээ зохицуулах, худалдаа хийх, цахим орчинг ашиглах зэрэг чадвартай эсэхийг өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны Лавтон үнэлгээгээр (Хүснэгт 9) сувилагч, нийгмийн ажилтан, нийгмийн халамжийн ажилтан үнэлж тодруулна.

Хүснэгт 9

Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагаа буюу настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварыг тодорхойлох Лавтоны үнэлгээ

Чадвар	Үнэлэх шалгуур	Оноо
Та өөрөө хоолоо бэлтгэж чаддаг уу?	Тусламжгүйгээр чадна	2
	Хэн нэгний тусламж шаардана	1
	Хийж чадахгүй	0
Та гэрийн ажлаа өөрөө хийж чаддаг уу?	Тусламжгүйгээр чадна	2
	Хэн нэгний тусламж шаардана	1
	Хийж чадахгүй	0
Хувцасаа угааж чадах уу?	Тусламжгүйгээр чадна	2
	Хэн нэгний тусламж шаардана	1
	Хийж чадахгүй	0
Та эмээ жорын зааврын дагуу ууж чаддаг уу?	Тусламжгүйгээр өгсөн зааврын дагуу тохирох тунгаар, заасан цагт ууж чаддаг.	2
	Хэн нэгний тусламжтай / хэн нэгэн сануулах эсвэл бэлтгэж өгвөл уудаг/	1
	Эм уух чадваргүй	0
Та хол зайд явган явж чаддаг уу?	Өөрийн машинаар болон автобус таксигаар явж чадна	2
	Гадуур явахдаа туслагчтай хамт явна	1
	Гадуур явж чадахгүй	0
Та дэлгүүрт худалдаа хийж	Өөрөө дэлгүүр яваад хэрэгцээт зүйлээ худалдан авч чадна	2

чаддаг уу?	Хэн нэгний хамт дэлгүүр явж хэрэгцээтэй зүйлээ цуглуулж чадна	1
	Худалдаа хийж чадахгүй	0
Та мөнгөө өөрөө зарцуулж чаддаг уу?	Мөнгийг зарцуулж чадна	2
	Өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай мөнгө зарцуулж чадна.Төлбөр чек бичихэд тусалцаа шаардана.	1
	Мөнгө зарцуулж огт чадахгүй	0
Та утсаар ярьж чаддаг уу?	Бусдын тусламжгүйгээр ярих дугаар хийж залган, дуудлага хүлээн авч утсаар ярьж чаддаг	2
	Утасны дугаар цуглуулах залгахад тусламж шаардана	1
	Утас ашиглаж огт чадахгүй	0
Цахим орчимд ажиллаж чаддаг уу	Цахим орчимд ажиллаж чадна	2
	Хааяа тусламж шаардлагатай	1
	Цахим орчимд огт ажиллаж чадахгүй	0
Нийт оноо		18










Настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварыг үнэлэх шалгуураар 15-18 оноо авсан бол **“бие даан амьдарч чадна”**, 10-14 оноо авсан бол **“бие даах чадвар алдагдсан”** гэж үзэж асран хамгаалагч болон гэр бүлийн дэмжлэгтэй амьдрах боломжтой ч тус үнэлгээгээр 0 оноо авсан чадвар тус бүрийг үнэлнэ. 6-9 оноо авсан бол **“Асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн байнгын дэмжлэг хэрэгтэй”** гэж үнэлнэ.

В.8.1.4. Насны доройтол нь насжилтын үйл явцтай холбоотой бие махбодын олон эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны нөөц аажмаар алдагдах эрүүл мэндийн өөрчлөлт юм.

Насны доройтлыг таньж илрүүлэх, алдагдсан чадварыг нэмж алдагдуулахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор сувилагч, нийгмийн ажилтан үнэлж, хянана.

Доройтлын эмнэлзүйн үе шатыг үнэлэх үнэлгээ

Доройтлын эмнэлзүйн үе шат

-  1. Маш сайн - Найдвартай, идэвхтэй, эрч хүчтэй, урам зоригтой, эдгээр хүмүүс ихэвчлэн дасгал хөдөлгөөн тогтмол хийдэг, тэд насандаа хамгийн их зохицсон /0,09 (0,05)/
-  2. Сайн - Өвчний шинж тэмдэггүй, гэхдээ идэвхтэй, хаала дасгал хийдэг насны зохицол 1-р ангилалаас арай бага. Тэд ихэвчлэн дасгал хийдэг. Хаала идэвхтэй /0,12 (0,05)//
-  3. Боломжийн сайн - Өвчнөө сайн хянуулдаг. Өдөр тутам байнга алхдаггүй. /0,16 (0,07)/
-  4. Эмзэг - Өдөр тутмын үйл ажиллагаа хараат бус хэдий ч, шинж тэмдэг нь үйл ажиллагааг хязгаарладаг. Ихэвчлэн ядрах, үйл хөдлөл удаахрах гэсэн зовиуртай байна. /0,22 (0,08)/
-  5. Бага зэрэг доройтолтой - Өдөр тутмын үйл ажиллагаанд удаашрал хангалттай мэдрэгдэнэ. Ачаалал шаардагдсан өдөр тутмын үйл ажиллагаа санхүүгийн тооцоо хийх, унаагаар явах, хүнд хэлбэрийн гэрийн ажил, эмчилгээ хийх зэрэгт тусламж шаардлагатай. Бага зэргийн доройтол нь аажим худалдан авалт хийх, ганцаараа гадагш алхах, хоол бэлтгэх, гэрийн ажил хийх үйл ажиллагааг алдагдуулна. /0,27 (0,09)/
-  6. Дунд зэргийн доройтол - Гэрээс гадуурх бүх үйл ажиллагаа, гэр цэвэрлэхэд тусламж хэрэгтэй. Гэр дотор шатаар явах, усанд орох зэрэгт байнга асуудал үүснэ. Зогсох, хувцаслахад бага зэрэг тусламж хэрэгтэй. /0,36 (0,09)/
-  7. Хүнд доройтол - Хувь хүний тусламж бусдаас бүрэн хамааралтай. (биеийн болон танин мэдэхүйн.) Гэхдээ 6 сарын дотор тогтвортой нас барах өндөр эрсдэлгүй /0,43 (0,08)/
-  8. Маш хүнд доройтол - Бусдаас бүрэн хамааралтай. Амьдралын төгсгөлийн шатанд байна. Бага зэргийн өвчлөл байсан ч эдгэрэхгүй.
-  9. Эцсийн шатны өвчлөлтэй - Амьдралын үргэлжлэх хугацаа 6 сараас доош байна. Бүрэн доройтолтой

Деменцитэй үед, насны доройтлын зэрэг нь ихэвчлэн деменцийн зэрэгтэй ойролцоо байдаг байна.

- Бага зэргийн деменци - Сүүлийн үеийн үйл явдлаа мартаж, зарим зүйлсийг санаж байгаа ч гэсэн ижил асуултаа олон давтан асуух зэрэг багтана.
- Дунд зэргийн деменци - Сүүлийн үеийн ой санамж ихээр алдагдсан, гэхдээ өнгөрсөн амьдралын үйл явдлыг сайн санадаг. Тэд бусдын дэмжлэгтэй өөрийгөө асарна.
- Хүнд зэргийн деменци - Бусдын тусламжгүй биеэ дааж чадахгүй.

K. Rodwood et al. A global clinical measure of fitness and frailty in elderly people. CMAJ 2006; 173:489-495

© 2011-2012 Weston LA
All rights reserved Under Canada

Доройтлын эмнэлзүйн үе шатны үнэлгээгээр 1-5 оноо авсан бол “Доройтолгүй ахмад настан”, Доройтлын эмнэлзүйн үнэлгээгээр 5 оноо авсан ч асран хамгаалагчгүй ахмад настан болон дээрх үнэлгээгээр 6 ба түүнээс дээш оноо авсан ахмад настанг “Дундаас дээш доройтолтой эмзэг бүлгийн ахмад настан” гэж үнэлж, тус настанд “Хэрэгцээний цогц үнэлгээ”-г хийнэ. Харин “Доройтлын түвшин дунд зэрэг” гэж үнэлэгдсэн ч тухайн настан асран хамгаалагчтай, асаргаа хангалттай байвал сэргээн засах эмчилгээ, амралт, сувиллын газар болон эрүүл, идэвхтэй насжилтын дэмжих төвийн үйл ажиллагаанд идэвхтэй хамруулахаар нийгмийн халамжийн байгууллагад холбон зуулчилна.

Дундаас дээш доройтолтой эмзэг бүлгийн настан, бие даах чадвар алдагдсан, хэвтрийн болон хөгжлийн бэрхшээлтэй настанд ихэнхдээ цооролт их үүсдэг Иймээс Нортонь шалгуур (Хүснэгт-11)-аар цооролтыг үнэлнэ.

Хүснэгт 11

Цооролтын эрсдэлийг үнэлэх Нортонь шалгуур

Биеийн байдал	Сайн	4	
	Дунд	3	
	Муу	2	
	Маш муу	1	
Сэтгэцийн байдал	Сэргэг	4	
	Хямралтай	3	
	Самуурсан	2	
	Унтаа	1	
Биеийн идэвх	Хэвийн	4	
	Явахад туслалцаа авдаг	3	
	Тэргэнцэртэй	2	
	Хэвтрийн	1	
Хөдөлгөөний байдал	Хэвийн	4	
	Ялимгүй хязгаарлагдсан	3	
	Маш их хязгаарлагдсан	2	
	Хөдөлгөөнгүй	1	
Өтгөн, шээсээ барих чадвар	Хэвийн	4	
	Тохиолдлоор	3	
	Шээс задгайрсан	2	
	Өтгөн, шээсээ хамт задгайрсан	1	

Цооролтын эрсдэлийг сувилагч үнэлнэ. Нортонь шалгуураар 18 ба түүнээс дээш байгаа тохиолдолд “цооролт үүсэх бага эрсдэлтэй”, 18-14 оноо авсан бол “дунд эрсдэл”, 14-10 оноотой бол “цооролт үүсэх өндөр эрсдэл”-тэй гэж оношилж, цооролт үүсэх эрсдэлтэй гадаргууг тус тус тодорхойлно. Харин 9 ба түүнээс доош оноо авсан “маш өндөр эрсдэлтэй буюу цооролттой” гэж оношилж, арьсны үнэлгээ хийнэ. Арьсны үнэлгээгээр цооролт 3-4 зэрэгтэй үнэлэгдвэл эмнэлэгт илгээнэ.

В.8.1.5. Бие даах чадвар алдагдсан, байнгын асаргаа сувилгаа, хараа хяналт шаардлагатай ахмад настанг харж асрахад асран хамгаалагч нарт эрүүл мэнд, нийгэм, санхүүгийн асуудал тулгардаг. Иймээс асран хамгаалагчийн ачааллыг Заритийн асуумж (Хүснэгт 10)-аар үнэлж ачаалалд тохирсон нийгэм халамжийн тусламж, үйлчилгээг үзүүлэх нь ахмад настны амьдралын чанарт эерэгээр нөлөөлдөг.

Хүснэгт 12

Асран хамгаалагчийн ачааллыг үнэлэх Заритийн асуумж

Өөрт чинь тохирч буй хамгийн зөв хариултыг хариуцлагатай дугуйлна уу?	Огт үгүй	Бага зэрэг	Заримдаа	Нилээд	Маш их

1	Таны асруулагч өөрийн байгаа хэрэгцээнээсээ илүү их зүйлийг гуйж шаарддаг юм шиг санагддаг уу?	0	1	2	3	4
2	Та асруулагчтайгаа ихэнх цагийг өнгөрүүлснээс болж өөртөө хангалттай цаг гаргаж чадахгүй байна гэж боддог уу?	0	1	2	3	4
3	Та ахмад настанг асрах ажил болон гэрийн ажилдаа бухимддаг уу?	0	1	2	3	4
4	Таны асруулагчын зан авир танд төвөг учруулдаг уу?	0	1	2	3	4
5	Та асруулагчтайгаа байх үедээ уур уцаартай байдаг уу?	0	1	2	3	4
6	Асруулагч чинь танд гэр бүлийн бусад гишүүн болон найз нөхөдтэйгээ яг одоогийн харилцах харилцаанд чинь сөргөөр нөлөөлж байна гэж та боддог уу?	0	1	2	3	4
7	Асруулагчийг чинь цаашид ямар ирээдүй хүлээж байгаа бол гэхээс айдаг уу?	0	1	2	3	4
8	Асруулагч чинь танаас хамааралтай юм шиг санагддаг уу?	0	1	2	3	4
9	Та асруулагчтайгаа байхдаа бүх хүч чадлаа дайчилдаг юм шиг санагддаг уу?	0	1	2	3	4
10	Асруулагчаасаа болоод та эрүүл мэндээрээ хохирч байна гэж боддог уу?	0	1	2	3	4
11	Асруулагчаас чинь болж таны хувийн амьдрал хүссэн шиг тань байж чадахгүй байна уу?	0	1	2	3	4
12	Асруулагчаа халамжилснаас болоод таны нийгмийн амьдрал хохирч байна гэж үздэг үү?	0	1	2	3	4
13	Асруулагчаасаа болоод найз нөхдийн тухайд танд ямар нэг асуудал тулгардаг уу?	0	1	2	3	4
14	Асруулагч чинь таныг өөрийнхөө цорын ганц асран халамжлагч гэж боддог уу?	0	1	2	3	4
15	Танд асруулагчаа халамжлахад нэмэлт үердалд захцуулагдах мөнгө хангалттай байдаг уу?	0	1	2	3	4
16	Асруулагчаа халамжлах хугацаа цаашид удаан үргэлжилбэл танд түүнийг халамжлах боломж бололцоо байгаа юу?	0	1	2	3	4
17	Асруулагч чинь өвдсөнөөс болоод та өөрийн амьдрал ахуйдаа тавих хяналтаа алдсан уу?	0	1	2	3	4
18	Та асруулагчаа халамжлах үүргээ өөр хэн нэгэнд орхих юм сан гэж хүсдэг үү?	0	1	2	3	4
19	Та асруулагчдаа хийж өгөх зүйлсээ чухалчилж үздэг үү?	0	1	2	3	4
20	Та асруулагчдаа зориулж илүү их зүйл хийх хэрэгтэй гэж боддог уу?	0	1	2	3	4
21	Та асруулагчаа асран хамгаалж байхдаа илүү сайн ажил хийж чадна гэж боддог уу?	0	1	2	3	4

22	Эцэст нь таны асруулагчаа халамжлах ачаалал чинь хэр зэрэг байна гэж боддог вэ?					
Нийт оноо						

Асуумжийн талаар болон түүний ач холбогдлын талаар тайлбарлан ойлгуулна. Асран хамгаалагчийн ачааллыг үнэлэх асуумжаар 0-20 оноо авсан асран хамгаалагчийг “огт ачаалалгүй”, 21-40 оноотой бол “бага зэргийн ачаалалтай”, 41-60 оноо авсан тохиолдолд “заримдаа ачаалалтай” гэж үнэлэн, ачаалалтай байгаа шалгуурыг тодруулна. Харин 61-88 оноо авсан асран хамгаалагчийг “маш их ачаалалтай” гэж дүгнэнэ.

В.8.1.6 Ахмад настан хүчирхийлэлд өртөж буй эсэхийг илрүүлэх

Ахмад настанг хүчирхийллээс сэргийлэх, ангид байлгах нь тэдний эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжихэд маш чухал ач холбогдолтой.

Ихэнхдээ даах чадвар буурсан буюу бие даах чадваргүй, өдөр тутмын үйл ажиллагааны чадвар алдагдсан, ахмад настны олон хам шинжтэй, асран хамгаалагчгүй, ганц бие ахмад настан нь бусдаас хараат байдалд орж, хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй. Иймээс дараах шинж төрх, байдал настанд ажиглагдаж байгаа эсэхийг ажиглаж илрүүлнэ. Үүнд:

- ✓ Асран хамгаалагчаас айдаг,
- ✓ Асран хамгаалагчийн үл хайхрах байдал,
- ✓ Асуухад хариулахыг хүсдэггүй, эсвэл хариулахаасаа өмнө асран хамгаалагч руугаа санаа зовсон харцаар хардаг,
- ✓ Асран хамгаалагч нь өрөөнд орж гарах үед зан байдал өөрчлөгддөг,
- ✓ Асран хамгаалагчаа "ширүүн, ууртай" эсвэл ихэвчлэн "муухай аашилдаг" гэж хэлэх,
- ✓ Настан тэдний дэргэд маш тайван бус болох гэх мэт

Харин асран хамгаалагчийн зүгээс гарч болох дараах зан төлвийг анхаарна:

- ✓ Эсвэл ахмад настантай ганцаарчлан ярилцахад саад болох, хориглох, эсвэл үнэлгээний ярилцлагыг тасалдуулах шалтгаан хайсаар байх (жишээлбэл, өрөөнд удаа дараа орох),
- ✓ Ахмад настнаас асуусан асуултад урдуур нь орж хариулдаг,
- ✓ Ахмад настанд гэртээ тусламж үзүүлэхэд саад болдог, асран халамжилж байгаадаа сэтгэл ханамжгүй байдгаа харуулах,
- ✓ Эмч мэргэжилтэнд ахмад настанг "галзуу" эсвэл солиорсон гэж итгүүлэх оролдлого хийх,
- ✓ Ярилцлагын үеэр шавдуулсан, яаруулсан эсвэл тэвчээргүй байх.

Биеийн бодит үзлэгээр:

- ✓ настны бие дээр хүчирхийллийн зарим ул мөр болох шалтгаан тодорхойгүй зүсэлт, түлэгдэлт,
- ✓ хөхөрсөн, зураас,
- ✓ тэдний өгсөн тайлбартай тохирохгүй гэмтлүүд,
- ✓ санамсаргүй тохиолдох магадлал багатай гэмтэл, далд газарт үүссэн гэмтэл, шарх, янз бүрийн үе шатанд эдгэрч буй болон эмчлэгдээгүй гэмтэл,

- ширүүн барьцалдсанаас болж хуруу шиг хэлбэртэй хөхөрсөн (ихэнхдээ гарны дээд хэсэг),
- эмийг дутуу эсвэл хэтрүүлэн хэрэглэх гэх мэт шинж тэмдгүүдийг ажиглаж, илрүүлнэ.

В.8.2. Настны нийгмийн байдалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс

- Ахмад настны олон хам шинжтэй,
- Архаг өвчтэй,
- Ганц бие, харж асрах хүнгүй,
- Гэрт амьдардаг, нийтийн байр түрээслэдэг,
- Хүчирхийлэлд өртөх, ганцаардах эрсдэлтэй,
- Бие даах чадвар бүрэн алдагдсан, асран хамгаалагч зайлшгүй хэрэгцээтэй

В.8.3. Нийгмийн халамж хэрэгцээтэй настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ

Настны нийгмийн байдал, нийгмийн халамжийн хэрэгцээний үнэлгээний дүнд үндэслэн тусламж, үйлчилгээг төлөвлөн үзүүлэхдээ Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад холбон зуучилна.

Настны бие даах чадвар болох хооллох, хувцаслах, усанд орох, хөдөлгөөн, бие засах, өтгөн шингэнээ барих чадварыг тодорхойлох КАТЗ-ийн үнэлгээгээр “Бие даах чадвар бүрэн алдагдсан-асран хамгаалагч зайлшгүй хэрэгцээтэй”, “Бие даах чадвар алдагдсан” настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ:

- ✓ “0” оноо авсан чадвар бүрт зориулсан тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- ✓ Үзүүлэхдээ сувилахуйн үйл ажиллагааны 5 шатлалын дагуу асаргаа, сувилгааны төлөвлөгөөг боловсруулж, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- ✓ Хяналтыг сувилагч өдөр бүр хийж, сувилгааны тэмдэглэлд хөтөлнө.
- ✓ Амин үзүүлэлт хэвийн хэмжээнээс өөрчлөгдсөн тохиолдолд эмчид хандана.
- ✓ Хооллох, хувцаслах, усанд орох, бие засах, гэр дотор болон гэрээс гарах тохиолдолд асран хамгаалагч заавал шаардлагатай гэдгийг гэр бүл, асран хамгаалагчдад сувилагч, нийгмийн ажилтан, нийгмийн халамжийн ажилтан зөвлөнө.
- ✓ Нийгмийн байдалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс, настны хам шинж (шээс задгайрах, явганаас унах, ухаан санаа дэмийрэн балартах г.м), олон эмийн хэрэглээ, танин мэдэхүйн чадвар буурсан, бие даах чадваргүй, эрүүл мэндийн байдал дордсон, харж асрах хүнгүй ахмад настанд урт хугацааны асаргаа, халамжийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг нийгмийн халамжийн байгууллага, кейс менежерийн багт холбон зуучилна.

“Бие даах чадвар хэвийн, өөрийгөө асрах чадвартай” гэж үнэлэгдсэн настанд дараах тусламж, үйлчилгээг үзүүлнэ:

- ✓ Настан болон гэр бүл, асран хамгаалагчдад эрүүл мэндийн зөвлөгөө өгнө
- ✓ Настанг ахмадын төв, эрүүл мэндийн төв, эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих төв гэх мэт олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ дэмжлэг авах талаар мэдээлэл өгч хамруулах арга хэмжээ авна.

- ✓ Настны бие даах чадварыг сайжруулах, алдагдсан чадварыг сэргээн засахын тулд нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгсэл (сонсгол, харааны ортопед, нүдний шил, суултуур, таяг, тэргэнцэр, гэрэлтүүлэг, гэр орны аюулгүй байдлыг бүрдүүлэх, эмийн хайрцаг, таних тэмдэг, шошго г.м)-ийг нийлүүлдэг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын мэдээлэл өгч, нийгмийн халамжийн байгууллагатай холбон зуучилна.

Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагаа буюу настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварыг тодорхойлох шалгуураар "Бие даах чадвар алдагдсан" настанд:

- ✓ асран хамгаалагч болон гэр бүлийн дэмжлэгтэй амьдрах боломжтой ч тус үнэлгээгээр 0 оноо авсан чадвар бүрт үр хүүхэд, асран хамгаалагч нарын туслалцаа хэрэгтэй гэдгийг ойлгуулж, зөвлөнө.
- ✓ Тэдэнд хүнсний бүтээгдэхүүн цуглуулан өгөх, хоол хийхэд бэлдэж өгөх, хувцас угаах, гэр орны ажил хийх, санхүүгийн асуудлыг зохицуулах, тэтгэвэр тэтгэмжийг авчирч өгөх, уух эмийг худалдан авч өгөх, уух цаг, дэглэмийг тодорхой бичиж, бэлдэж өгөх гэх мэт тусламж шаардсан хэсэгт дэмжлэг үзүүлэх тусламж, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад холбон зуучилна.

"Настны багаж хэрэгсэлтэй ажиллахад асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн байнгын дэмжлэг хэрэгтэй" настанд:

- ✓ Хоолоо бэлтгэх, гэрийн ажлаа бие даан хийх, хувцасаа угаах, эмээ жорын дагуу уух, хол зайд явган алхах, худалдаа хийх, мөнгөө өөрөө зарцуулах, утсаар ярих, холбогдох, цахим орчин ашиглахад гэр бүлийн гишүүдийн дэмжлэг байнга хэрэгтэй гэдгийг онцлон анхааруулж зөвлөнө.
- ✓ Өдөр тутмын үйл ажиллагааны алдагдлыг илрүүлсэн ажилтан нь тухайн харъяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, сувилал, уламжлалт болон сэргээн засахын төв, өдрийн сэргээн засах төв, сувилахуйн төв, дасгалын клуб, идэвхтэй насжилтыг дэмжих төв, настны өдөр өнжүүлэх төвд холбон зуучилна.
- ✓ Өдөр тутмын үйл ажиллагааны алдагдлыг засах төлөвлөгөө гарган, бие бялдар, ахуйн сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- ✓ Байнгын асаргаа шаардлагатай, хэвтрийн ахмад настанд гэрээр сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилгоор хөдөлгөөн засалч, сэргээн засахын эмч, сувилагч, хөдөлмөр засалч, нийгмийн ажилтан эсвэл олон мэргэжлийн багт хандаж тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Хүчирхийллийн ул мөр, шинж ажиглагдсан үед авах арга хэмжээ

Түүнийг таслан зогсоох, хохирогчийг хамгаалах тусламж, үйлчилгээг хамтарсан баг, олон мэргэжлийн баг, кейс менежертэй хамтран нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөн үзүүлнэ:

- ✓ Хамтарсан багт мэдээлнэ.
- ✓ Хүчирхийллийн улмаас хүнд, ноцтой бэртэл, гэмтэл авсан настанд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэн, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэг, эсхүл шүүх эмнэлэгт холбон зуучилна.

- ✓ Хохирогч настанг гэрт нь үлдээх нь амь нас, эрүүл мэндэд аюултай гэж үзвэл насанд хүрэгчдийн хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хууль сахиулах үйлчилгээнд холбон зуучилна.
- ✓ Гэр бүлийн бусад гишүүдэд шилжүүлэн асруулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- ✓ Эрсдэлт нөхцөлд байгаа настанд сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад нь туслах анхан шатны сурган, сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй холбон зуучилна.

Өвчний олон улсын ангилал ICD10 - R54 буюу насны доройтлыг холбогдох оношилгоо, эмчилгээний зааврын дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Насны доройтлын зовуурь шаналгааны нэг болох цооролтыг эмчлэх нь чухал юм.

“Цооролт үүсэх эрсдэлтэй” настанд дараах нийтлэг тусламж, үйлчилгээг үзүүлнэ:

- ✓ цооролтын шалтгаан болон цооролт үүсэх эрсдэлтэй гадаргууг нь тодорхойлж, сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх,
- ✓ настны ор, хувцас болон тэргэнцрийн гадаргууг цэвэр, үрчгэргүй засах,
- ✓ хоолны нэр төрлийг олон болгож, илчлэг амин дэмээр баялаг хоол өгөх,
- ✓ даралт үүсэхээс сэргийлэн хүний биеийн хөдөлгөөнөөр хуваарилагдаж холголт цооролтоос сэргийлдэг гудас, зориулалтын цагираг ивүүрийг санал болгох гэх мэт.

Харин цооролт үүсэх эрсдэлтэй настны байрлалыг цагийн зүүний дагуу 2 цаг тутам, цооролт үүсэх дунд эрсдэлтэй настанг 2-1.5 цаг тутам, цооролт үүсэх өндөр эрсдэлтэй үед байрлалыг 1.0 цаг тутамд сольж, байрлал шилжүүлнэ. “Маш өндөр эрсдэлтэй буюу цооролттой” настны арьсны үнэлгээний дүнд үндэслэн холбогдох эмчилгээ, асаргаа, сувилгааг үзүүлэх ба арьсны үнэлгээгээр цооролтын 3-4 зэрэгтэй үнэлэгдвэл эмчид үзүүлнэ.

Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтрийн настанг асарч, сувилахад гэр бүл, үр хүүхэд, асран хамгаалагч нарт нийгэм-эдийн засгийн болон эрүүл мэндийн хувьд их ачаалал, дарамт ирдэг. Иймээс дараах нийгмийн халамж, үйлчилгээг үзүүлнэ:

- ✓ Асран хамгаалагч **“огт ачаалалгүй”** бол цаашид хэрхэн сувилах талаар сувилагч эрүүл мэндийн зөвлөгөө өгнө.
- ✓ **“Бага зэргийн ачаалалтай”**, **“заримдаа ачаалалтай”** үнэлэгдсэн тохиолдолд ачаалалтай байгаа шалгуурыг тодруулан зөвлөгөө өгөхөөс гадна асран хамгаалагч бэлтгэх мэргэжлийн сургалтанд хамруулна.
- ✓ **“маш их ачаалалтай”** гэж үнэлсэн тохиолдолд ачааллыг бууруулах дараах зөвлөгөөг өгнө. Үүнд:

Асран хамгаалагчийн ачааллыг бууруулахдаа нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран ажиллана:

- ✓ Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай тохиолдолд настны гэр бүл, үр хүүхдүүд зөвшилцөн хуваарь гаргаж, түүний дагуу жигд оролцоог ханган асран халамжлах,

- ✓ Асран хамгаалагч ачаалалтай, эрүүл мэндийн асуудалтай үед тэднийг амралт, сувилалд түр амраах, орлон асрах асаргааны ажилтанг томилох, ахмад настанг түр байршуулах асрах төв болон сувिलाхуйн төв, өдрийн асаргааны төв, хосписд илгээх,
- ✓ гэр бүлийн бусад гишүүдэд шилжүүлэн асруулах талаар нийгмийн ажилтан гэр бүл үр хүүхдүүдтэй нь зөвшилцөн шийдвэрлэх,
- ✓ Ахмад настны эрүүл мэнд, асаргаа сувилгааны асуудлаар асаргаа, сувилгааны чиглэлээр сургалтад хамруулах,
- ✓ Эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих төвийн Кэйс менежментийн үйлчилгээнд бүртгүүлэн хамруулна.

Гамшиг, нийгмийн ноцтой байдлын үед Ахмад настанд чиглэсэн хариу арга хэмжээг авах сургалтыг зохион байгуулна.

В.8.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ болон нийгмийн халамжийн үйлчилгээнд илгээх заалт

- Дундаас дээш доройтолтой эмзэг бүлгийн ахмад настанд эрүүл мэндийн эрсдэл төдийгүй танин мэдэхүйн чадварын бууралт, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай байвал урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлдэг төвүүдэд ажилладаг кейс менежерүүдэд илгээж "Хэрэгцээний цогц үнэлгээ"-г хийлгэх,
- Байнгын асаргаа шаардлагатай, хэвтрийн ахмад настны архаг хууч өвчин, ахмад настны хам шинж даамжирсан тохиолдолд илгээнэ.

Г.ХЯНАЛТ

- Аймаг, дүүргийн гериатр эмчийн хяналтад эмчийн заалтын дагуу хянагдана.
- Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан настныг хам шинжийн үнэлгээний дүнд үндэслэн хянах хугацааг товлону.

АГУУЛГА.

ОРШИЛ.

А.ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- A1. Хэрэглэгчид
- A2. Зааврын зорилго
- A3. Зааварт ашигласан нэр томъёо, тодорхойлолт, эх сурвалж
- A4. Тархварзүйн мэдээлэл
- A5. Тавилан

Б. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

- Б.1. Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, асрамжийн төв болон лавлагаа шатлалын эмнэлгийн түвшинд түвшинд
- Б.2 Зорилтот бүлэг
- Б.3. Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө

В. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ (АЛГОРИТМ)

В.1. НАСТНЫ ЦОГЦ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ХҮРЭЭ

- В.1.1.Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPE үнэлгээ
 - Хүснэгт 1. Ахмад настны 6 хам шинжийг илрүүлэх сорил
- В.1.2.Эрүүл настанд үзүүлэх нийтлэг эмчилгээ, зөвлөгөө
- В.1.3. Хам шинжтэй настанд үзүүлэх нийтлэг эмчилгээ, зөвлөгөө
- В.1.4. Архаг хууч өвчин сэдэрсэн, тусламж, үйлчилгээ авч чадахгүй гэртээ байгаа настанд үзүүлэх нийтлэг эмчилгээ, зөвлөгөө
- В.1.5. Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж үзүүлэх шалгуур

В.2. ТАНИН МЭДЭХҮЙН ЧАДВАРЫГ БУУРАЛТЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

- В.2.1. ICOPE үнэлгээний танин мэдэхүйн чадварыг бууралтыг лавшруулан оношлох алгоритм
 - Хүснэгт 2. Одоогийн сэтгэцийн байдлыг үнэлэх Фолштэйны буюу Mini–Mental State Examination (MMSE) сорил
 - Хүснэгт 3. Танин мэдэхүйн хөнгөн зэргийг үнэлэх асуумж (Montreal Cognitive Assessment - MoCA)
- В.2.2. Танин мэдэхүйн чадвар бууралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс
- В.2.3.Танин мэдэхүйн чадвар буурсан үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө
- В.2.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

В.3. ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДВАР БУУРАЛТЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

- В.3.1.ICOPE үнэлгээний хөдөлгөөний чадвар бууралтыг лавшруулан оношлох алгоритм
 - Хөдөлгөөний чадвар бууралтыг үнэлэх "Сандлаас босч суух сорил"
 - Зураг 3 . Биеийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн сорил
- В.3.2. Хөдөлгөөний чадвар бууралтад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

V.3.3. Хөдөлгөөний чадвар буурсан үед үзүүлэх үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө
V.3.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

V.4. ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДОРОЙТЛЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

V.4.1. ICOPE үнэлгээний хоол тэжээлийн доройтлыг лавшруулан оношлох алгоритм
- Хүснэгт 4. Хоол тэжээлийн доройтлыг илрүүлэх, үнэлэх шалгуур- Mini Nutrition Assessment- MNA

V.4.2. Хоол тэжээлийн доройтолд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

V.4.3. Хоол тэжээлийн доройтлын үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

V.4.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

V.5 ХАРААНЫ БЭРХШЭЭЛИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

V.5.1 ICOPE үнэлгээний харааны бэрхшээлийг лавшруулан оношлох алгоритм

V.5.2. Харааны бэрхшээлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

V.5.3.Харааны бэрхшээлийн үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

V.5.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

V.6. СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

V.6.1 ICOPE үнэлгээний сонсголын бэрхшээлийг лавшруулан оношлох алгоритм

V.6.2. Сонсголын бэрхшээлд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

V.6.3.Сонсголын бэрхшээлийн үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

V.6.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

V.7. СЭТГЭЛ ГУТРАЛЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

V.7.1. ICOPE үнэлгээний сэтгэл гутралыг лавшруулан оношлох алгоритм

- Хүснэгт 5. Настны сэтгэл гутралыг үнэлэх (GDS) илрүүлгийн асуумж

- Хүснэгт 6. Айдас түгшүүр, сэтгэл гутралыг түвшинг үнэлэх (HADS) илрүүлгийн асуумж

V.7.2. Сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

V.7.3.Сэтгэл гутралын үед үзүүлэх эмчилгээ, зөвлөгөө

V.7.1.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

V.8.НАСТНЫ НИЙГМИЙН БАЙДАЛ, ХАЛАМЖИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

V.8.1 Настны нийгмийн байдал, халамжийн хэрэгцээг үнэлэх алгоритм

V.8.1.1 Олон мэргэжлийн болон хамтарсан баг, кейс менежерийн үзүүлэх нийгмийн халамж, дэмжлэг, тусламж, үйлчилгээ

V.8.1.2 Настны бие даах чадварыг КАТЗ-ийн үнэлгээ

V.8.1.3. Өдөр тутмын бүтээлч үйл ажиллагааны Лавтон үнэлгээ

V.8.1.4. Доройтлын эмнэлзүйн үе шатны үнэлгээ

V.8.1.5. Асран хамгаалагчийн ачааллыг үнэлэх Заритийн асуумж

V.8.1.6 Ахмад настан хүчирхийлэлд өртөж буй эсэхийг илрүүлэх


V.8.2. Настны нийгмийн байдалд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлс

V.8.3. Нийгмийн халамж хэрэгцээтэй настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ

V.8.4.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээнд илгээх заалт

Г. ХЯНАЛТ


Зураг 1. Танин мэдэхүйн чадвар бууралттай ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний зураглал



Зураг 4. Хөдөлгөөний чадвар бууралттай ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний зураглал



Зураг 5. Хоол тэжээлийн доройтолтой ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний зураглал




Зураг 6. Харааны бэрхшээлтэй ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний зураглал



Зураг 7. Сонсголын бэрхшээлтэй ахмад настанд үзүүлэх цогц, тусламж үйлчилгээний зураглал



Зураг 8. Сэтгэл гутралтай ахмад настанд үзүүлэх цогц, тусламж үйлчилгээний зураглал



**Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний зааврыг
боловсруулсан ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

М.Оюунчимэг, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичиг:

Ц.Хандармаа, ЭМЯ-ны ЭТҮГ-ын АЛШТХ-ийн Сувилахуйн тусламж,
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Ч.Одгэрэл, Геронтологийн үндэсний төвийн эмнэлгийн тусламж
үйлчилгээний албаны дарга асан, Тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны доктор

Гишүүд:

Д.Оюун-Эрдэнэ, НЭМГ-ын Сувилахуй, хөнгөвчлөхийн тусламж, үйлчилгээ
хариуцсан ахлах мэргэжилтэн, Сувилахуйн ухааны докторант,
Сувилахуйн тэргүүлэх зэрэгтэй,

Т.Ганцэцэг, СЭМҮТ-ийн Тандалт, судалгааны албаны дарга, АУ-ны доктор

Ц.Болормаа, АШУҮИС-ийн Монгол анагаах ухааны төв эмнэлгийн Ахлах
сувилагч, Сувилахуйн ухааны магистр, Зөвлөх зэрэгтэй,

Н.Алтанзул, Монголын сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний нийгэмлэгийн
тэргүүн, АУ-ны доктор, сэтгэцийн ахлах зэргийн эмч

Л.Одгэрэл, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн багш, Сувилагч
мэргэжлийн зөвлөх зэрэгтэй, Сувилахуйн ухааны магистр

Р.Оюунханд, Насжилт судлал, настны эмгэг судлалын нийгэмлэгийн
тэргүүн, Анагаах Ухааны доктор, Удирдахуйн ухааны магистр, Клиникийн
профессор, Дотрын зөвлөх зэргийн эмч,

Д.Нямсүрэн, Монголын сувилагчдын нийгэмлэгийн тэргүүн, Удирдахуйн
ухааны докторант, дэд профессор, сувилахуйн зөвлөх зэрэгтэй

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЛШТХ-Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтэс

АШУҮИС-Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

НЭМГ-Нийслэлийн эрүүл мэндийн газар

СЭМҮТ-Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

ДЭМБ-Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ICOPE – Integrated care for older people

MNA- Mini Nutrition Assessment

MMSE- Mini–Mental State Examination

mhGAP- Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ

ХТБ-Хоол тэжээлийн байдал

HADS- Hospital Anxiety and Depression Scale

ЭМЯ- Эрүүл мэндийн яам

ЭТҮГ- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар

НОМЗҮЙ

1. Ахмад настны тухай хууль
2. Нийгмийн халамжийн тухай хууль
3. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнэ тогтоох тухай" 153 дугаар тогтоол,
4. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай" хамтарсан А/807, А/216 дугаар хамтарсан тушаал,
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Журам батлах тухай" А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаал
6. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Эмнэлзүйн хоол эмчилгээний заавар" батлах тухай
7. Эрүүл мэндийн сайдын 2012 оны "Настны сувилахуйн удирдамж батлах тухай" 01 дүгээр тушаал
8. Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Заавар батлах тухай" А/517 дугаар тушаал
9. MNS 4621:2008 Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд
10. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага "Номхон далайн баруун бүсийн эрүүл насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө", Улаанбаатар хот, 2021 он
11. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага "Эрүүл насжилтын арван жил суурь нөхцөл байдлын тайлан" Улаанбаатар хот, 2022 он
12. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийг бэлтгэх (ToHP) сургалтын гарын авлага, Улаанбаатар хот
13. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага "Настны цогц тусламж, үйлчилгээ-Дотоод чадамж бууралтыг удирдахад чиглэгдсэн олон нийтэд суурилсан хөтөлбөрт үйл ажиллагааны удирдамж"
14. Integrated care for older people (ICOPE)" Guidance on person-centered assessment and pathways in primary care" World Health Organization Handbook, 2019